МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

MONGOLIA

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖЛИЙН ТӨВ

# НҮҮДЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ


МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗОЧЛОХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БАГ

"АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН СУДАЛГАА, ИННОВАЦИЙН ТӨВ" НҮТББ



Монгол улс
2019 он

**НҮҮДЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ СУДАЛГААНЫ БАГ:**


**Судалгааны багийн ахлагч:**

MSc С.Мөнхнасан. дэд профессор. МҮИС-ийн АЖГХС-ийн захирал

"Аялал жуулчлалын судалгаа, инновацийн төв" НҮТББ-ийн Тэргүүн

АЖ-ын тэргүүний ажилтан, БТА, "Байгаль орчны хяналт үнэлгээ"-ний докторант

**Судалгааны багийн зөвлөх:**

1. Д.Гансүх. Доктор Ph.D, профессор, "Аялал жуулчлалын Тогтвортой хөгжил" НҮТББ-ийн Тэргүүн

**Судалгааны багийн гишүүд:**

1. О.Сүхбаатар. Доктор Ph.D, профессор
2. Ч.Мөнжаргал. Доктор Ph.D, дэд профессор
3. Н.Энхмагнай. MSc, БО-ны докторант. МҮИС-ийн АЖЗҮ-ний тэнхмийн эрхлэгч
4. М.Болортуяа. MSc, "Аялал жуулчлалын судалгаа, инновацийн төв" НҮТББ-ийн судлаач
5. Б.Ербахыт. MSc, МҮИС-ийн аялал жуулчлалын багш

   М.Намуун. МҮИС-ийн аялал жуулчлалын магистрант



**ТАЛАРХАЛ**

Энэхүү төлөвлөгөө нь Монгол улс нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болохын тулд өнөөгийн нөхцөл, нөөц боломж болон өрсөлдөөний орчин судлан үзэж, улмаар 2030 он хүртэл хэтийн төлөв, зорилгыг тодорхойлон хэрэгжүүлэх алхамуудыг санал болгох зорилготой хийгдсэн судалгааны ажил дээр үндэслэгдсэн юм.

Төлөвлөгөөг боловсруулахад бүх талын дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан БОАЖЯ-ны АЖБЗГ, БСШУСЯ-ны СУГ, АЖХТ, СУИС, АЖТХТ, МҮИС-ийн АЖГХС болон судалгааны явцад мэдээлэл, саналаа хуваалцсан аялал жуулчлалын багш, судлаачид, орон нутгийн мэргэжилтэнүүд болон нийт хүмүүст гүн талархлаа илэрхийлье.



Улаанбаатар хот

2019 он

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Товч хураангуй

Судалгааны арга зүй

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1 Үндэслэл ба эрхзүйн орчин

1.2 Нүүдлийн аялал жуулчлал, түүний үзэл баримтлал

1.3 Монгол улсад НАЖ хөгжиж буй өнөөгийн нөхцөл байдал

1.4 НАЖ хөгжих нөөц боломж ба хэрэглэгчийн судлагаа

1.5 SWOT анализ

**ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГОЛ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД БА СТРАТЕГИ**

2.1 НАЖ-ыг Монгол улсад хөгжүүлэх алсын хараа, эрхэм зорилго

2.2 НАЖ-ыг хөгжүүлэх зорилтууд ба стратегийн чиглэл

**ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

3.1 НАЖ-ыг хөгжүүлэх аялал жуулчлалын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгох

3.2 Монгол улсын НАЖ-ын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэх

3.3 НАЖ-ыг хөгжүүлэхэд орон нутгийн хөгжил, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах

3.4 Олон улсын ба бүс нутгийн хамтын ажиллагаанд суурилсан Монгол улсын НАЖ-ын хөгжилд шинэ технологи, инновацийг нэвтрүүлж, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэх

3.5 НАЖ-ыг сургалт, судалгаанд суурилан хөгжүүлэх

3.5 Санхүүгийн төлөвлөлт ба санхүүжилтийн эх үүсвэр

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НҮҮДЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТЭРГҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД**

Судлан хэрэгжүүлэх томоохон төслүүдийн жагсаалт

**ТАВДУГААР БҮЛЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА ХЯНАЛТ, МОНИТОРИНГ**

5.1 Удирдлага, зохион байгуулалт

5.2 Эрсдлийн менежмент, хяналтын тогтолцоо

5.3 НАЖ хөгжүүлэх замын зураглал, гарах үр дүн

**ХАВСРАЛТ**

- Судалгааны материалууд
- Нотлох баримтууд
- Дэлгэрэнгүй мэдээлэлүүд

**ХҮСНЭГТ**

*Хүснэгт 1.*
*Хүснэгт 2.*
*Хүснэгт 3.*
*Хүснэгт 4.*
*Хүснэгт 5.*
*Хүснэгт 6.*
*Хүснэгт 7.*
*Хүснэгт 8.*
*Хүснэгт 9.*
*Хүснэгт 10.*
*Хүснэгт 11.*
*Хүснэгт 12.*
*Хүснэгт 13.*
*Хүснэгт 14.*
*Хүснэгт 15.*
*Хүснэгт 16.*
*Хүснэгт 17.*
*Хүснэгт 18.*
*Хүснэгт 19.*
*Хүснэгт 20.*
*Хүснэгт 21.*
*Хүснэгт 22.*
*Хүснэгт 23.*
*Хүснэгт 24.*
*Хүснэгт 25.*
*Хүснэгт 26.*
*Хүснэгт 27.*
*Хүснэгт 28.*
*Хүснэгт 29.*
*Хүснэгт 30.*
*Хүснэгт 31.*
*Хүснэгт 32.*
*Хүснэгт 33.*
*Хүснэгт 34.*
*Хүснэгт 35.*
*Хүснэгт 36.*
*Хүснэгт 37.*
*Хүснэгт 38.*
*Хүснэгт 39.*
*Хүснэгт 40.*
*Хүснэгт 41.*
*Хүснэгт 42.*
*Хүснэгт 43.*
*Хүснэгт 44.*
*Хүснэгт 45.*
*Хүснэгт 46.*
*Хүснэгт 47.*

**ЗУРАГ**

*Зураг 1.*
*Зураг 2.*
*Зураг 3.*
*Зураг 4.*
*Зураг 5.*
*Зураг 6.*
*Зураг 7.*
*Зураг 8.*
*Зураг 9.*
*Зураг 10.*
*Зураг 11.*
*Зураг 12.*
*Зураг 13.*
*Зураг 14.*
*Зураг15.*
*Зураг 16.*
*Зураг 17.*
*Зураг 18.*

**ДИАГРАММ**

*Диаграмм 1.*
*Диаграмм 2.*
*Диаграмм 3.*
*Диаграмм 4.*

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| АЖБЗГ | Аялал Жуулчлалын Бодлого Зохицуулалтын Газар |
| АЖБХН | Аялал Жуулчлалын Боловсрол Хөгжлийн Нийгэмлэг |
| АЖСИТ | Аялал Жуулчлалын Судалгаа Инновацийн Төв |
| АЖТХТ | Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжлийн Төв |
| АЖХТ | Аялал Жуулчлалын Хөгжлийн Төв |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БОАЖЯ | Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам |
| БСШУСЯ | Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам |
| ГХЯ | Гадаад харилцааны яам |
| ДАЖБ | Дэлхийн Аялал Жуулчлалын Байгууллага |
| ДНБ | Дотоодын Нийт Бүтээгдэхүүн |
| ДЦГ | Дархан Цаазат Газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| МАЖХ | Монголын Аялал Жуулчлалын Холбоо |
| МЗБХ | Монголын Зочид Буудлуудын Холбоо |
| МҮИС | Монголын Үндэсний Их Сургууль |
| НАЖ | Нүүдлийн Аялал Жуулчлал |
| НАЖГ | Нийслэлийн Аялал Жуулчлалын Газар |
| НҮБ | Нэгдсэн Үндэсний Байгууллага |
| ОХУ | Оросын Холбооны Улс |
| НҮТББ | Нийгэмд Үйлчлэх Төрийн Бус Байгууллага |
| СУИС | Соёл Урлагийн Их Сургууль |
| ТСАЖ | Тусгай Сонирхлын Аялал Жуулчлал |
| ТХГН | Тусгай Хамгаалалттай Газар Нутаг |
| УБ | Улаанбаатар |
| ҮСГ | Үндэсний Статистикийн Газар |
| ХЗЯ | Хууль Зүйн Яам |
| ШУА | Шинжлэх Ухааны Академи |
| ЭМЯ | Эрүүл Мэндийн Яам |

## ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

**Товч хураангуй**

**Судалгааны арга зүй:**

### 1.2. Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулсан арга зүй

Энэхүү төлөвлөгөөг боловсруулах, судалгаа хийх, нэгтгэн дүгнэхэд дараах аргуудыг ашигласан болно. Үүнд:

- Нөхцөл байдлын шинжилгээг SWOT анализ аргаар
- Стратегийн чиглэлийг TOWS матрицын аргаар
- Асуулга судалгааг анкет болон ярилцлагын аргаар
- Гадаад жуулчны тоон өсөлтийн хэтийн төлөвийг регрессийн шинжилгээгээр
- Дотоодын амрагчдын тоон өсөлтийн төлвийг А.Б.Агаповагийн болон Н.С.Мироненкогийн аргачлалаар тус тус хийж гүйцэтгэлээ.



## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

### 1.1 Үндэслэл ба эрхзүйн орчин

**Төлөвлөгөөний хэрэгцээ, шаардлага:**

2017 онд Монгол улсад аялсан гадаадын 1350 жуулчныг санамсаргүй түүврийн аргаар, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч 42 аж ахуй нэгжээс асуулгын аргаар авсан Монгол банкны “Монгол улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа”-наас үзэхэд 28% нь Монголын нүүдлийн ахуй, зан заншилыг танин мэдэхээр, 14% нь Монголын түүхийг сонирхож, 36% нь байгаль, ан амьтанг сонирхохоор тус тус хүрэлцэн ирсэн байх бөгөөд тур операторуудын үйлчилгээг 38% нь маш сайн, 33% нь сайн, 19% нь дунд, 8% нь муу, 2% нь маш муу гэж үнэлсэн ба улмаар нийт жуулчдын 89% нь Монгол Улсад дахин ирнэ гэж хариулжээ.[1]

Өөрөөр хэлбэл манай орны аялал жуулчлалын гол бүтээгдэхүүн, нөөц нь үзэсгэлэнт унаган байгальд нүүдэллэн амьдрах уламжлалт өв соёл, түүх болох нь харагдаж байна.




*Диаграмм 01. Нүүдлийн соёлын ахуй, зан заншлыг сонирхож ирсэн жуулчдын хувь*

Гэвч 2019 онд Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг аялал жуулчлалын салбарын өрсөлдөх чадварын индекст оролцсон нийт 140 орноос Монгол Улс 93-р байранд эрэмбэлэгдсэн нь 2017 оны 101 дүгээр байрнаас урагшилсан үзүүлэлт боловч хангалттай сайн биш юм.[2]

Ийм учраас уламжлалт нүүдлийн соёл иргэншилийн өв уламжлал, түүх соёлын дурсгалууд, байгалийн нөхцөл, нөөцдөө тулгуурлан аялал жуулчлалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага тулгараад байна.

Манай орныг зорин ирэх жуулчдын жил тутам тоо өсөн нэмэгдэж байгааг жуулчдын тооны өсөлт 2016 онд 4,44%, 2017 онд 14,21%[3], 2018 онд /529,370/ 29,6% байгаагаас харж болох юм. Гэвч үйлчилгээний чанар муу, бүс нутгуудын аялал жуулчлалын бүтээгдэхүүнүүдийн харилцан ялгарал, төрөлжилт байхгүй зэргээс шалтгаалан нэг ирсэн жуулчид дахин эргэж ирэх тоо хэмжээ маш хангалтгүй байна.




*Диаграмм 02. Жуулчны тооны өсөлтийн хувь*

[1] Монгол банк “Монгол улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа” 2017 он УБ
[2] World Economic Forum “The Travel & Tourism Competitiveness Report 2019” Geneva 2019
[3] www.travelmongolia.org

/2019 оны судалгаанд хамрагдсан жуулчдын ...% нь Монгол улсад 2 ба түүнээс дээш удаа дахин ирсэн жуулчид байжээ./

Аялал жуулчлалын салбар дэлхий дахинд хурдацтай хөгжин дэлхий нийтийн жууулчдын урсгал Ази, Номхон далайн бүс нутагруу давамгайлах хандлагатай болж буй энэ цаг үед Монгол улсын 2030 он хүртэлх "Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал"-д Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, **Нүүдлийн соёл, аялал жуулчлалын төв болох зорилго тавьж**, эдийн засгийн "Тэргүүлэх гурван салбар"-ын болгон хөгжүүлэхээр тусгасан тул үүнийг хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулах хэрэгцээтэй байна.

Иймд Монгол улсын дэд бүтцийн хангамж, байгаль түүх соёлын дурсгалын онцлог, өөр өөрийн гэсэн давуу тал бүхий эдийн засгийн бүсүүдэд онцлог ялгарал бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгон гадаад харилцаагаа өргөжүүлэх замаар "Дэлхийн Нүүдлийн соёл, аялал жуулчлал"-ын төв болж хөгжихийн тулд урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан ажиллах хэрэгцээ шаардлага тулгараад байна.

**НАЖ-ыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах эрх зүйн орчин, хэрэгжүүлж буй бодлого**

Монгол улсад "Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө"-г боловсруулах эрхзүйн үндэслэл баримт бичгүүд:

- **"Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үзэл Баримтлал-2030" бодлогын баримт бичигт хөгжлийн тэргүүлэх 3 салбарын нэгт "Аялал жуулчлал"-ын салбар байхаар төлөвлөж "Нүүдлийн аялал жуулчлалын олон улсын төв" болох зорилт дэвшүүлснийг хэрэгжүүлэх үндэслэл болгон**
- **Монгол улсын "Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай" хуулийн** 10.1 хэсэгт "Үндэсний хөтөлбөрт төрөөс баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, арга хэмжээг нарийвчлан төлөвлөсөн байна" хэмээн заасныг үндэслэл болгон
- Монгол Улсын ногоон хөгжлийн бодлого-д **"Эрүүл ахуйн шаардлага хангасан, эко аялал жуулчлалыг хөгжүүлнэ"** гэсэн зорилтуудыг дэвшүүлснийг үндэслэн
- **"Монгол улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн** 4.4.2 хэсэгт "...Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ" хэмээн заасныг хэрэгжүүлэхийн тулд тус үндэслэл болгон энэхүү төлөвлөгөөг боловсруулсан болно.

Монгол Улсад хэрэгжиж буй урт хугацааны болон орон нутгийн бодлогын бичиг баримтуудад тусгагдсан Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлийн заалтуудыг хүснэгтлэв. Аялал жуулчлал, соёл, соёлын хот төлөвлөлтийн нийт 5 бичиг баримтад Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхээр 11 заалт тусгагдсан байна.

1. **Салбарын бодлогын бичиг баримтууд:**

*Хүснэгт 1. Нүүдлийн аялал жуулчлалтай холбоотой зорилтууд*

| № | Бодлогын бичиг баримтын нэр | Уялдаж буй зорилт, заалт | Уялдаж буй дэд ажлууд |
|---|---|---|---|
| 1 | Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал - 2030<br><br>/УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол/ | 2.1.2. Монгол Улс Нүүдлийн аялал жуулчлалын олон улсын төв болох | “Монгол Улс Нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болно” болох зорилтыг гурван үе шаттай хэрэгжүүлж, жуулчдын тоог 2020 онд 1 сая, 2025 онд 1.5 сая, 2030 онд 2.0 саяд хүргэхээр төлөвлөжээ. |
| 2 | Аялал жуулчлалын үндэсний хөтөлбөр<br><br>/ЗГ-ын 2015 оны 324 дугаар тогтоол/ | Нийт 6 зорилт, 24 дэд зорилттой | 4.2.1. аялал жуулчлалыг Монгол орны байгаль, түүх, соёлын үнэт өв, нүүдэлчин ахуй, уламжлалт зан заншлыг тусгасан өөр өөрийн онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээний ялгаатайгаар бүсчлэн хөгжүүлэх;<br>4.2.3. соёлын өв, түүх, соёлын дурсгалт газарт суурилсан соёлын аялал жуулчлалын шинэ үйлчилгээ, үйлдвэрлэлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх; |
| 3 | Соёлын үйлдвэрлэл үндэсний хөтөлбөр<br><br>\Засгийн газрын 2015 оны 509 дүгээр тогтоол\ | Нийт 6 зорилт, 40 дэд зорилттой | 4.1.8. соёлын аялал жуулчлалын төрөл, чиглэл, маршрутын дагуу түүх соёлын өвүүдийг олон нийтэд сурталчлан таниулах, үзэсгэлэн яармаг, худалдаа зэрэг арга хэмжээ зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;<br>4.3.6. аялал жуулчлалын кластерын хүрээнд гар урлал, бэлэг дурсгал, гадаад, дотоодын жуулчдад зориулсан үзвэр, үйлчилгээ, соёлын цогц арга хэмжээг бий болгох;<br>4.6.4. монгол уран бүтээлчдийн шилдэг бүтээлийг шалгаруулж, олон улсын зах зээлд сурталчилах, худалдах, олон улсын нэр хүндтэй байгууллагад ажиллуулах үйл ажиллагааг зохион байгуулах; |
| 4 | Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр<br><br>/УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол/ | 3.2. Үндэсний болон сонгодог урлаг, нүүдлийн соёл иргэншлийг төрийн ивээлд байлгаж, бүх нийтийн соёл урлагийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, соёл урлагийн аялал жуулчлал, гадаадад монголын үндэсний соёл урлагийг сурталчилах үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгож, монгол контентийг хөгжүүлнэ. | 3.2.47.Соёл урлагийн аялал жуулчлал хөгжүүлэх, гадаадад монголын үндэсний соёл урлагийг сурталчилах, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох талаар тусгайлсан бодлого хэрэгжүүлнэ<br>4.4.2.Үндэсний зан заншил, уламжлал, түүх, соёл, унаган байгаль, нүүдэлчин ахуйг түшиглэсэн аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлж, нийслэл, аймаг, бүс нутгийн онцлогт тохирсон аялал жуулчлалын дэд хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ. |

| | | | |
|---|---|---|---|
| 5 | Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага<br><br>/УИХ-ын 2013 оны 23 дугаар тогтоол/ | “Ирээдүй үеийнхний хэрэгцээнд тохирсон тэдэнд хор учруулахгүй бөгөөд одоогийн хэрэгцээнд нийцэх хөгжлийг баримтлан гадаад, дотоодын жуулчдын сохирхолыг татсан нүүдэлчдийн аялал жуулчлалын төв хот” болгон хөгжүүлэх | Дугаар: 2021-2030/16<br>Номад ланд аялал жуулчлалын чөлөөт бүс “Nomad Land FTZ” , 2020 оноос.<br><br>Дугаар: 2021-2030/17<br>“Нүүдэлчдийн хот” орон нутгийн музей, 2021 оноос<br><br>Дугаар: 2012-2020/23<br>“Монгол наадам” үндэсний соёл, урлагийн цогцолбор, 2013-2018 он |

2. **Бусад салбарын бодлогын бичиг баримтууд**

*Хүснэгт 2. Бусад салбарын бодлогын бичиг баримтуудад НАЖ-ыг хөгжүүлэхтэй холбоотой тусгагдсан заалтууд*

| № | Бодлогын бичиг баримтын нэр | Уялдаж буй зорилт, заалт | Уялдаж буй дэд ажлууд |
|---|---|---|---|
| 1 | Эдийн засгийг сэргээх хөтөлбөр<br>/УИХ-ын 2016 оны 71 дүгээр тогтоол/ | 2.1.Уул уурхайн бус салбарын экспортын орлогыг нэмэгдүүлж, эдийн засгийг төрөлжүүлэх үндэс суурийг тавих, | 2.1.3.Аялал жуулчлалын гол маршрутын зам дагуу түр буудаллах цэг, үйлчилгээний цогцолбор байгуулах; |
| 2 | Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр<br><br>/УИХ-ын 2017 оны 142 дугаар тогтоол/ | Зорилт 8. Авто замын үндсэн коридорыг түшиглэн аялал жуулчлалын парк, төрөлжсөн цогцолбор, хилийн боомтын аялал жуулчлалын кластер байгуулж, аялал жуулчлалыг үндэсний хэмжээнд бүсчлэн хөгжүүлнэ. | 3.8.2. “Мянганы суут хүн Их Эзэн Чингис хаан” түүхэн аялал жуулчлалын үндэсний парк байгуулах (Хэнтий аймаг);<br>3.8.3. “Монголын эзэнт гүрэн” аялал жуулчлал, музей, судалгаа, сурталчилгааны цогцолбор байгуулах (Төв аймаг);<br>3.8.4. Дэлхийн өв-Орхоны хөндийн аялал жуулчлалын үндэсний парк байгуулах;<br>3.8.5. Өгий нуурын экосистемийн тэнцвэрийг хадгалах, хамгаалах аялал жуулчлалын цогцолбор байгуулах;<br>3.8.6. Хөвсгөл аймагт нутгийн иргэдэд түшиглэсэн байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын цогцолбор байгуулах;<br>3.8.7. “Буянт-Ухаа” аялал жуулчлалын цогцолбор байгуулах ажлыг эхлүүлэх, |
| 3 | Орос-Монгол-Хятад улсын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр<br><br>\БНУУ-ын нийслэл Ташкент хотод 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөр гарын үсэг зурсан\ | Хүмүүнлэгийн хамтын ажиллагаа | 28. Хил дамнасан бүс нутаг хоорондын аялал жуулчлалын чиглэлүүдийг хөгжүүлэх, тухайлбал, Монголын Хөвсгөл нуур, Оросын Байгаль нуур, Хятадын Хөлөнбуйр нуурыг оруулсан “Их нууруудын гурвалжин”, мөн түүнчлэн Монгол-Орос-Хятадын аялал жуулчлалын тойргийг бий болгох<br>29. Монгол-Орос-Хятадын олон улсын аялал жуучлалын “Цайны их зам” брэндийг бий болгох |

| | | | |
|---|---|---|---|
| 4 | Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого<br><br>УИХ-ын 2014 оны 43 дугаар тогтоол | Стратегийн зорилт 1. Байгалийн нөөцийн хэмнэлттэй, хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай үйлдвэрлэл, хэрэглээг хөгжүүлнэ. | 3.1.7.байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх; |

***Цаашид боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлого хөтөлбөрүүд:***

- ❖ Аялал жуулчлалын бүсчилсэн хөгжлийн дэд хөтөлбөр
- ❖ MICE буюу албан, бизнес жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр
- ❖ Хил орчмын болон хил дамнасан аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030” бодлогын бичиг баримтын 2.1.2 дахь заалтанд “Монгол Улс Нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын төв болох” зорилт тусгагдсан. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад бодлогын бичиг баримтуудад аялал жуулчлалыг хөгжүүлэх, нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх тухай нийт 7 зорилт, аялал жуулчлалтай холбоотой бусад 13 заалт тусгагдсан байгаа тул Монгол Улсад “Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх” эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрэн бүрдсэн гэж үзэв. Гэхдээ цаашид НАЖ-ыг хөгжүүлэхэд илүү таатай эрхзүйн орчинг бүрдүүлэхийн тулд “Аялал жуулчлалын тухай хууль” болон бусад журам, эрхзүйн баримт бичгүүдэд нэмэлт өөрчлөлт хийгдэх шаардлагатай хэмээн үзэж энэхүү төлөвлөгөөний 1-р зорилтонд холбогдох ажлуудыг тусгасан болно.

Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилго, зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөг дээрх бүх заалтуудад уялдуулан боловсруулав.

## 1.2 Нүүдлийн аялал жуулчлал, түүний үзэл баримтлал

***A. Нүүдлийн аялал жуулчлалын талаар онолын судалгаа***

Нүүдлийн аялал жуулчлалын онол, арга зүйн зарим судалгаанууд хийгдсэн ба эдгээр судалгаанууд нь нүүдэлчдийн ахуй соёл, тэдэнд аялал жуулчлалын хөгжлөөс үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөллүүд, хот руу зорьсон нүүдэл, хотжилт зэрэг антропологийн судалгаатай холбоотой байна. Нүүдлийн аялал жуулчлалын олон улсын ба дотоодын судалгааны төвүүд, судлаачдаас нэрлэвэл:

- Монгол улсын нийслэл Улаанбаатар хотод төвтэй “Нүүдлийн соёл, иргэншлийн хүрээлэн” / **The International Institute for the Study of Nomadic Civilizations** /. Анх 1998 онд Монгол, Турк, Казахстан, Киргизстан улсууд хамтран ЮНЕСКО-гийн ивээлд байгуулсан энэхүү Хүрээлэн одоо ШУА-ын нэгэн төрөлжсөн хүрээлэн болж, нүүдлийн соёлын чиглэлээр дагнасан академик судалгааг хийж байна. (http://www.nomadic.mn/projects )
- “Төв Азийн аялал жуулчлал” /Tourism in central Asia : Cultural Potential and Challenges edited by K. Kantarci, PhD, M. Uysal, PhD, V.P. Magnini, PhD/ гэсэн судалгааны бүтээлд нүүдлийн аялал жуулчлалын онол-практикийн асуудлуудыг багтаасан байна.
- Судлаач Uradyn E. Bulag НҮБ-ын ДАЖБ-ын Ази, номхон далайн төвөөс зохион байгуулсан “Монголын нүүдлийн соёл ба аялал жуулчлалын семинарын гол илтгэгч төдийгүй “Mongolian Heritage Crusade: Perspectives from Mongolia and China” http://www.socanth.cam.ac.uk/directory/dr-uradyn-e-bulag судалгааг хэвлүүлсэн.

• Глазгогийн Их Сургуулийн аялал жуулчлалын багш Guillaime Tiberghien “Казахстаны аялал жуулчлал ба бодит байдал. Хуучин ЗХУ-ын дараахь нүүдлийн шинэ соёл” сэдвээр доторын зэрэг горилсон судалгааны ажлыг хэвлүүлсэн.

• Монгол улсын Аялал Жуулчлалын Тогтвортой Хөгжлийн Төвөөс Торгоны замын дагуу нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх судалгааг проф.доктор Д.Гансүхийн удирдлагаар явуулж 2016 онд “НҮБ-ын ДАЖБ-ын Торгоны замын аялал жуулчлал. Нүүдлийн мөрөөр аялахуй” номыг хэвлүүлсэн.

• АНУ-ын Техасын Их Сургуулийн антропологийн тэнхимийн судлаач Cynthia Ann Werner Монголын аялал жуулчлалын судалгааг явуулж, “Nomadic Culture and International Tourism Development in Mongolia” гэсэн судалгааны өгүүлэл бичиж нийтлүүлсэн.

• ОХУ-ын Москва хот дахь Нүүдлийн соёлын музейн захирал, аялагч Konstantin Kuksin www.nomadic.ru нүүдэлчин ардууд, тэдний ахуй, зан заншлын талаар судалгаа хийж, Оросын Маяк радиогоор http://www.nomadic.ru/staff/; http://radiomayak.ru/guests/guest/id/218002/ сурталчилсан байна.

***Б. “Нүүдэлчдийн соёл” аялал жуулчлал***

“Аялал жуулчлалын мэргэжлийн зөвлөлийн уулзалт”-аас хийсэн “ЖАЙКА-гийн Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа”-ны материалд дурьдсанаар “Амралт аялал жуулчлал”-ын “Эко аялал жуулчлал”-ын төрлийн “Соёлын аялал жуулчлал”-ын нэг хэлбэр нь “Нүүдэлчдийн соёлын аялал жуулчлал” хэмээн үзсэн ба энэ нь амьдралын хэв маягт тулгуурласан соёлын чиглэлийн аялал бөгөөд бусад аж үйлдвэрийн салбартай хослуулах нөөц боломжтой, олон талт нөлөө бүхий аялал жуулчлал гэж үзжээ.

Нүүдлийн аялал жуулчлалын бизнесийн аялал жуулчлалын төрөлд соёлын чиглэлийн арга хэмжээ хамаарах бөгөөд энэ нь түүх соёлыг хамгаалах, нүүдэлчин ард иргэдийн амьжиргааг сайжруулах ач холбогдолтой гэж үзсэн байна.

**“Нүүдэлчдийн соёл” амралт аялал жуулчлалын талаар дэвшүүлж буй таамаглал:**

1. Нүүдэлчдийн амьдралтай танилцах (байрлах байр сууц, үйл ажиллагаа, баяр ёслол г.м) нөөцийг тодорхойлох, улмаар нутгийн иргэдтэй хамтран тэдгээрийн үнэ цэнийг бусдад түгээх
2. Нүүдэлчдийн амьдралыг бүхий л талаар нь харуулсан мэдээллийн суурь баазыг бий болгож, тухайн сонирхолд нийцүүлэн мэдээлэл солилцох
3. Монголын үнэт байдал “Nomad by Nature”-ын дагуу, жуулчдын сонирхлыг татахуйц буудал, үйл ажиллагаа, баяр ёслол зэрэг олон талаас нүүдэлчдийн амьдралыг таниулах, сонирхуулах боломжийг нэмэгдүүлэх
4. Ирсэн жуулчин болгонд Монгол ***түүний хоёр дахь эх орон*** гэсэн гүнзгий сэтгэгдэл үлдээх

Өөрөөр хэлбэл ***Жуулчид болон нутгийн иргэдийн дэмжигчдийн дор*** тогтвортой нүүдлийн чөлөөт аялал жуулчлал хөгжинө гэж үзжээ.

Тус судалгааны “Аялал жуулчлалын уялдаа холбоо болон төвлөрсөн ерөнхий тойм” гэсэн хэсэгт “Нүүдэлчин” нөөц дээр тулгуурласан дараах төрлийн аяллууд хөгжих боломжтой хэмээн үзжээ. Үүнд:

- Нүүдэлчин амьдралтай танилцах аялал
- Нүүдэлчин соёлтой танилцах аялал
- Нүүдэлчдийн түүхтэй танилцах аялал
- Нүүдэлчдийн зохицон амьдарч буй байгаль дэлхийтэй нь танилцах аялал
- Нүүдэлчдийн өв соёлтой танилцах аялал хэмээн тус тус дурьдсан байна.

**Дүгнэлт:** Энэхүү “ЖАЙКА-гийн Монгол улсын бүсчилсэн хөгжлийн нэгдсэн судалгаа”-ны материалаас үзвэл дараах байдлаар дүгнэж болохоор байна. Үүнд:

- Нэр томъёоны хувьд тогтоогүй бөгөөд “Нүүдэлчдийн соёл” аялал жуулчлал, “Нүүдлийн аялал жуулчлал”, “Нүүдлийн соёл” аялал жуулчлал гэх зэргээр хэд хэдэн янзаар нэрлэсэн байна.
- Ямартай ч амралт аялал жуулчлалын эко аялал жуулчлалын хэсэгт хамруулан “Нүүдлийн аялал жуулчлал”-ыг багтаасан байна.

***B. Нүүдлийн аялал жуулчлал:***

Нүүдлийн аялал жуулчлал нь нэг төв газраас эхлээд байнга нүүдэллэн байраа сэлгэж аялах тусгай сонирхлын аялал жуулчлалын төрөл юм. Нүүдлийн аялал жуулчлал нв жинхэнэ нүүдэлчдийн соёл, ахуй амьдралыг сонирхож, улмаар морь, тэмээ зэрэг мал ахуйтай холбоотой зохион байгуулагддаг. Жуулчин нүүдэлчдийн нэгэн адил гэрт байрлаж, тэдний хоол ундыг зооглон морь тэмээ унаж, малчин ахуйн хэв маягаар амьдрах шаардлагатай болдог. Иймд нүүдэлчин ард түмний ахуй, соёл, зан заншилтай танилцаж сонирхох нь аяллын гол сэдэл, шалтгаан болсон жуулчдыг нүүдэлчний жуулчин гэж үзэх үндэстэй юм. Нүүдлийн АЖ-ын жуулчин морь мал унаж малчин ахуйд суралцахаас гадна байгалийн сайхныг сонирхож, унгана байгальтай харьцан соёлын өв дурсгалыг үзэж танилцан уламжлалт соёл, зан заншлын баяр, арга хэмжээнүүдэд идэвхитэй оролцож мөн түүнчлэн шашин мөргөл үйлдэх боломжтой байдаг. Нүүдлийн АЖ жуулчны төрлүүдийг зурагт үзүүлэв.




Судалгааны материалуудад нүүдлийн аялал жуулчлалыг гол төлөв Монгол улстай холбосон байдаг ба орсо хэл дээрхи зарим судалгаа “жайлоо аялал жуулчлал” буюу Киргизын гэрт байрлах ахуй зан заншлыг холбон авч үзсэн байна. Мөн түүнчлэн нүүдлийн аялал жуулчлалын онол, арга зүйг этно туризм буюу угсаатны аялал жуулчлал, адал явдалт аялал жуулчлал, экотуризм заримдаа экстрим аяллын хүрээнд авч үздэг талтай.

Ер нь зөвхөн гэрт хоноглон байрлахыг нүүдлийн аялал жуулчлал гэж үзэх үндэсгүй бөгөөд учир нь энэ нь ямар ч нүүдэллэх хөдөлгөөнгүй суурин байолалтай буюу одоо АНУ, Баруун Европын олон орнуудад хотод байнга барьсан гэрүүд сүүлийн жилүүд өсөн нэмэгдэж байна. Жишээлбэл: http://www.nomadplanet-portugal.com/#!accomodation/cvzr.

Нүүдлийн аялал жуулчлалыг Торгоны замын Төв Азийн зарим улс орнууд, одоогоор Монгол улс, Киргизстан болон ОХУ-ын зарим бүсүүд идэвхитэй сурталчилж байна.

Монгол улсын аялал жуулчлалын салбарт *өрсөлдөх чадвартай давуу тал* нэлээд байгаа ч гэсэн шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудлууд бас байна. Өрсөлдөх чадвартай давуу талд, дэлхийн өөр өнцөг буланд олоход бэрх өргөн уудам онгон байгаль, уламжлагдлан ирсэн нүүдлийн ахуй амьдрал орж байна.[4]

Мөн түүнчлэн “Монголын Торгоны замын аялал жуулчлалын концепц”-ийн нэг хэсэг нь Нүүдэлчин ард түмний байгалиа хадгалан хамгаалах уламжлалт арга, ухааныг

[4] “Аялал жуулчлалийг өргөжүүлэх, эдийн засгийн цаашдын хөгжлийг хангахын тулд байгалийн болон соёлын өв хөрөнгийн менежментийг бэхжүүлэх” 2011 он. 6ху

Монголын орчин үеийн суурин хотын хөгжлөөр илэрхийлэх явдал хэмээн зарим судлаачид тодорхойлжээ.[5] Улмаар Жуулчдын сонирхлыг татахуйц “Нүүдлийн аялал жуулчлал-Монголын торгоны зам” вэб хуудсыг бий болгох нь борлуулалтын чухал суваг болохыг дурьдсан байна.

“Нүүдлийн аялал жуулчлал ба хотуудын тогтвортой хөгжил” сэдэвт Торгоны замын олон улсын хурал 2016 оны 10-р сарын 13-нд Туушин зочид буудалд НҮБ-ын ДАЖБ, Монгол Улсын БОАЖЯ, “Дэлхийн хотуудын шинжлэх ухааны хөгжлийн холбоо” олон улсын байгууллага, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран зохион байгуулсан билээ.

Энэ хурлын үр дүнд Монгол Улс нүүдэлчин соёл иргэншлийн өв, түүхээ ашиглан одоогийн аялал жуулчлалыг нүүдлийн болгож, нүүдлийн аялал жуулчлал хэмээх өөрийн брэндийг бий болгохоор болсон бөгөөд энэ ойлголтонд XIII зууны нүүдэлчин ахуйг шинэ зууны нүүдлийн соёл иргэншилтэй хоршуулж, Улаанбаатар хотыг аялал жуулчлалын төв болгохоор төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний хамгийн чухал нь хэрхэн нүүдлийн аялал жуулчлалыг Монгол Улсын брэнд болгож, эдийн засгийн эргэлтэд оруулах тухай асуудал байлаа.[6]

***<u>Г. Нүүдлийн аялал жуулчлалын үзэл баримтлал:</u>***

Энэхүү төлөвлөгөөний судалгааны багийнхан соёлын аялал жуулчлал, нүүдэлчдийн соёл аялал жуулчлал, нүүдлийн аялал жуулчлал зэрэг ойлголтуудыг зарим талаар нэгтгэн, зарим талаар ялган ижил ба төсөөтэй талуудаар системчлэх санал дэвшүүлж байна. Үүнд:

Тусгай сонирхлын аялал жуулчлал
Соёлын аялал жуулчлал
Нүүдлийн аялал жуулчлал

“Нүүдлийн аялал жуулчлал” гэдэг нь язгуурын нүүдэлчин Монголчуудын байгаль эх дэлхийдээ нүүдэллэн амьдрах олон мянганы туршид хуримтлуулан өвлүүлсэн соёлын биет болон биет бус өвийн дурсгалууд дээр тулгуурлан явагдах “Соёлын аялал жуулчлал”-ын нэг чиглэл, “Тусгай сонирхлын аялал жуулчлал”-ын нэг төрөл юм.

“НАЖ” нь нүүдлийн соёл иргэншлийн өв дурсгалууд дээр тулгуурлах бөгөөд суурин соёл иргэншил дээр тулгуурлах соёлын аялал жуулчлалаас байгаль дэлхийтэй харьцах, дасан зохицох өвөрмөц онцлог шингэсэнээрээ ялгагдана. Иймд НАЖ-ыг Cultural, Community and Heritage Tourism ( CCH) буюу Соёлын, Нийгмийн бүлгийн, Үнэт өвийн аялал жуулчлалын нэг чиглэл болж Nomadic Tourism хэмээн томъёолж болно.




[5] Гансүх.Д, “Торгоны зам ба нүүдлийн аялал жуулчлал” 2017он. 19ху
[6] https://news.mn/r/747479/

**Нүүдлийн аялал жуулчлалын үндсэн зарчмууд:**[7]

1. НАЖ-н хөгжилд нутгийн иргэд малчдын оролцоог хангаж, эрх ашиг, сонирхлыг хамгаалах
2. Нүүдэлчин, малчдын өрхийн орлогыг дээшлүүлэх замаар орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах
3. Орон нутгийн нийгмийн амьдралын хэв шинжийг хадгалахуйц түвшинд аялал жуулчлалын нөлөөллийг хязгаарлах, хянах
4. Орон нутгийн түүх, соёл, зан заншлыг хүндэтгэж, хадгалахыг эрхэмлэх
5. Байгаль орчныг хамгаалах

НАЖ-ийг нөөцийн хувьд соёлын биет өвд тулгуурласан, соёлын биет бус өвд тулгуурласан, холимог буюу хосолсон хэлбэрийн гэж 3 ангилж үзлээ. Үүнд:

1. Соёлын биет өвд тулгуурласан НАЖ-ын хэлбэрүүдэд:
   - Сүм хийд, дуган, архитекторын дурсгал – Шашны аялал
   - Хадны зураг, бичээс – Археологийн аялал жуулчлал
   - Угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг – Угсаатны аялал жуулчлал
   - Гэр, сууц, тэдгээртэй холбоотой эд өлгийн зүйл – Танин мэдэхүйн аялал
   - Уламжлалт тоглоом наадгай – Танин мэдэхүй, амралтын аялал
   - Булш оршуулгын дурсгал – Археологийн аялал жуулчлал г.м
2. Соёлын биет бус өвд тулгуурласан НАЖ-ын хэлбэрүүдэд:
   - Эх хэл түүнтэй холбогдуулан утга уран зохиолын аман хэлбэрүүд
   - Ардын аман зохиол
   - Ардын язгуур урлаг
   - Гар урлал
   - Байгаль сав шим ертөнцийн тухай мэдлэг, арга ухааныг ашигласан үйл явдлын аялалууд г.м
3. Хосолсон НАЖ-ын хэлбэрүүдэд:
   - Сүм хийдийн ховор дурсгалын орчимд шашны зан үйлийг байгаль сав шим ертөнцийн тухай мэдлэгтэй хослуулан жуулчдад үзүүлэх үйл явдлын аялал буюу Эвентүүд. Жнь: Амарбаясгалант хийдийн Гонгорын бумбаны тахилга
   - Ардын аман зохиол, язгуур урлагийн гайхамшигийг уламжлалт хөгжмийн зэмсгээр тоглож үзүүлэх үзвэрүүд. Жишээ нь: "Түмэн эх" чуулгын морин хуурын тоглолт, хөөмийн хосолсон үзүүлбэрүүд г.м

**Дүгнэлт:** НАЖ нь САЖ-ын нэгэн төрөл хэлбэр бөгөөд нүүдлийн соёл иргэншлийн өв дурсгал, үнэт зүйл дээр тулгуурлан явагддагаараа онцлог юм. Монгол улсын соёлын аялал жуулчлал бол тэр чигээрээ НАЖ бөгөөд нөөцийн хувьд 3 үндсэн хэсэгт хуваан үзнэ.

Эдгээр НСАЖ-ын нөөц болон төрөл хэлбэрүүд нь зөвхөн соёлын өв дээр тулгуурлах төдийгүй "Нийлмэл өв" дээр ч тулгуурлан зохион байгуулагдах боломжтойг харгалзах шаардлагатай.

Цаашид НАЖ-ыг амьдралд бүрэн хэрэгжүүлэх дараахь чиглэлээр мэргэжлийн зөвлөлгөө авч, холбогдох төслүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна:

[7] "Нүүдлийн аялал жуулчлалын Монгол улсын стандартын шалгуурууд ба дүгнэх удирдамж" төсөл. АЖТХТ. Д.Гансүх. 2019он. 3ху

1. АЖХТ-ийн дэргэд сонирхогч талуудын оролцоо бүхий НАЖ-н зөвлөлийг байгуулж ажиллуулах,
2. НАЖ-ын зарчим, стандартуудыг үндэслэн Монгол улсын холбогдох хууль, журманд өөрчлөлт оруулах болон энэхүү шинэ стандартыг хэлэлцэн батлуулах,
3. Стандарт, шаардлагыг улам сайжруулах, түүний дотор НАЖ-ын стандартын үзүүлэлтүүдийг ойлгомжтой, бодитоор хэрэгжих, хэмжигдэхүйц болгож, үйл ажиллагаа явуулж буй мөн шинээр байгуулж буй аялал жуулчлалын байгууллагуудад (тур оператор, орон нутгийн зочид буудлууд, жуулчны баазууд зэрэг) заавар, удирдамж болгож ашиглах боломжтой болгоход мэргэжлийн туслалцаа үзүүлэх,
4. НАЖ-ын стандартын сургагч, шалгагч, шинжээч нарыг бэлтгэх, тэдэнд арга зүйн сургалт зохион байгуулж, үйл ажиллагааг зохицуулан удирдах,
5. Стандартын шалгуурыг хэрэгжүүлэх практик заавар, удирдамж боловсруулах, туслалцаа үзүүлэх,
6. Холбогдох чиглэлээр олон улсын, бүсийн ижил төсөөтэй байгууллагуудтай хамтран ажиллах,
7. Аялал жуулчлалын их, дээд сургуулиудын дипломын, бакалаврын, магистрын сургалтанд шинэ хичээл болон сонгон суралцах хичээлүүд санал болгох, туслалцаа үзүүлэх зэрэг болно.[8]

## 1.3 Монгол улсад НАЖ хөгжиж буй өнөөгийн нөхцөл байдал

### 1.3.1 Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлж буй гадаад орнуудын зарим туршлага

Дэлхий дахинд нүүдэлчдын соёл уламжлалаа хадгалан үлдсэн, эртний өлгий нутаг олон байдаг бөгөөд эдгээр улсууд эдийн засгийн чадавхи, нийгмийн харилцан адилгүй хөгжлөөсөө шалтгаалан аялал жуулчлалын нөөц болгон хөгжүүлж буй байдал янз бүр байдаг. Эдгээр улсуудын туршлагыг судлаж өөрийн орны аялал жуулчлалын хөгжилтэй харьцуулан авч үзэх нь цаашдийн бодлого, төлөвлөлтөнд чухал нөлөөтэй юм. Үүнд:

**Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлж буй зарим орнуудын харьцуулсан судалгаа**

Монголын аялал жуулчлалын хувьд өрсөлдөгч орнуудад төв азийн бусад орнууд орж болох бөгөөд үүнээс гол өрсөлдөгчид нь Монгол улстай газарзүйн байршилын хувьд ойр, аялал жуулчлалын нөхцөл, нөөц боломж нь адил төстэй шинж чанаруудыг үндэслээд Төвд, Өвөр Монгол, Казахстан, Киргизстан улсууд хэмээн тодорхойлж болно.

*Зураг 5.  Нүүдлийн аялал жуулчлалын бүс нутгууд*




[8] "Нүүдлийн аялал жуулчлалын Монгол улсын стандартын шалгуурууд ба дүгнэх удирдамж" төсөл. АЖТХТ. Д.Гансүх. 2019он. 3ху

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг "Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын тайлан"-н үзүүлэлтүүдээр Монгол улс болон дээрх 3 улсын /ӨМӨЗО, Төвд тус судалгаанд тусгагддаггүй/ өрсөлдөх чадварыг дараах диаграмм-д харьцууллаа.

*Зураг 6. Бүс нутагтаа өрсөлдөх чадварын харьцуулалт*




Тус харьцуулалтаас харахад, брэнд үүсгэх, үр ашигтай маркетинг хэрэгжүүлэх тал дээр нөгөө улсуудаасаа харьцангуй сул байгаа нь харагдаж байна. Харин Байгалийн болон соёлын нөөц ихтэй, тэдгээр нь Монголруу аялах шалтгаан болж чадаж байгаа тал дээрээ өрсөлдөгчдөөсөө илүү давуу талтай байна.

*<u>Монгол улсын НСАЖ-ын бүтээгдэхүүний бусад нүүдлийн аялалуудаас ялгарах онцлог, шинж чанар:</u>*

- Язгуурын нүүдэлчин буюу байгаль орчинтойгоо зохицон амьдарч ирсэн уламжлалдаа түшиглэсэн аялал жуулчлал гэдгээрээ онцлог
- Нүүдлийн соёл нь ертөнцийг үзэх үзэл, соёл, ахуйн өвөрмөц хэв маягийг өөртөө тээж байдаг бүхэл бүтэн ертөнц юм.
- Нийт хүн амын 20 орчим хувь нь одоог хүртэл нүүдэллэн амьдрах хэв маяг, уламжлалаа хадгалан үлдсэн ба соёлын биет бус өв тээгч олон байгаа зэрэг давуу тал нь "Нүүдлийн соёл иргэншилийн бодит, өвөрмөц онцлог" бүхий аяллын багцыг санал болгож байгаагаараа онцлог
- Өдгөө нүүдэлчин гэгдэх ард түмэнд Австралийн абориген, Бедуен, Масай, Пигмей, Туарег, Монгол, Төвд, Саамичуудыг батгаадаг болсон байна. Харин түүхэнд нүүдэлчин байсан угсаатнуудад – Скиф, Авар, Азербайжан, Башкер, Хүнну, Казах, Киргиз, Печенег, Полов, Сармат, Үзбек, Хазар, Цыган, Түрэг, Туркменүүдийг тооцдог гэж судлаачид үздэг байна.

### 1.3.2 Нүүдлийн соёл, уламжлалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож буй гадаад орнуудын туршлага:

*Хүснэгт 6. Дэлхийн Нүүдлийн аялал жуулчлалын зарим эвентүүдийг харьцуулсан судалгаа:*




Дээрх харьцуулсан хүснэгтээс харахад нүүдэлчдийн соёл, уламжлалыг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож байгаа улс орнуудын туршлага харилцан адилгүй боловч нэгдсэн байдлаар дараах дүгнэлтийг хийж болохоор байна. Үүнд:

- Нүүдэлчдийн соёлын наадмыг олон улсын тэмцээн, уралдаан хэлбэрээр жуулчдын оролцоог ханган зохион байгуулж байгаа туршлага байна.
- Нүүдэлчдийн соёлын олон өв дурсгал, уламжлалаас аль нэгийг нь товойлгон харуулж дэлхий дахинд брэнд болгон таниулж байгааг Киргизстаны жишээнээс /уламжлалт спорт тоглоом/ харж болохоор байна.
- Жуулчдын оролцоо, тэмцээн зохиохоос илүүтэй соёл уламжлалаа таниулах, үзүүлэх чиглэлийг түлхүү баримталж буйг Монгол улс, Унгар улсын жишээг дурьдаж болох юм.

### 1.3.3 Монгол улсад нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлж буй өнөөгийн байдал

***А. Нүүдлийн аялал жуулчлалын голлох бүс нутгууд***

Нүүдлийн аялал жуулчлалын голлох бүс нутгуудыг тодорхойлохдоо дараах чухал хүчин зүйлсийг харгалзах шаардлагатай. Үүнд:

- Брэнд бүтээгдэхүүн, нөөцийн тархац, байршил
- Жуулчдын урсгал

НАЖ-ын бүсчлэлийг бий болгосноор аялал жуулчлалыг эрчимжүүлэх, төрөлжсөн бүтээгдэхүүнээр ялгарч, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

НАЖ-ын онцлог байдал, тэдгээрийн ялгааг харуулсан бүс, дэд бүсүүдийн бий болгох замаар нутгийн иргэдийн аялал жуулчлал дахь оролцоо, нийгмийн идэвхийг бий болгох, угсаатны аж ахуй, төрөлжилт зэргээс хамааруулан дараах бүс, дэд бүсүүд байна.

НАЖ-ыг бүсчлэн хөгжүүлэхдээ газарзүйн байрлал, уур амьсгал, хотгор, гүдгэр, түүх соёлын дурсгалууд, дэд бүтэц, харилцаа холбоо зэрэг нөөцүүдийн иж бүрдэл нь тухайн бүс нутгийн аялал жуулчлалын өнгө төрхийг тодорхойлно. Энэхүү бүсүүд нь бусад аймаг орон нутаг, аялал жуулчлал хөгжиж байгаа дэд бүсүүдээс ялгагдах өвөрмөц, онцгой зүйлсийг бий болгоно хэмээн аялал жуулчлалыг амжилттай хөгжүүлснээр эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллийг дорвитой бий болгоно.

НАЖ-ыг хөгжүүлэх дараах хэд хэдэн бүс нутагт хуваан авч үзэж болно. Үүнд:

*Хүснэгт №1. НАЖ-ыг хөгжүүлэх бүсчлэн хөгжүүлэх*

| № | Бүсүүдийн нэр | Дэд бүсүүдийн нэр | Аж ахуй эрхэлдэг байдал, төрөлжилт |
|---|---|---|---|
| 1 | Баруун хязгаар бүс | Алтай таван богд, Хурган, Хотон нууруудын дэд бүс | Казах, Тува ноёлсон бүс нутаг |
| 2 | | Баян-Өлгийн казак, урианхайн дэд бүс | Казак үндэстний бүс нутаг, Ховдын Ховд, Мөнх хайрхан, Дуут сумд |
| 3 | | Увс нуур орчмын дөрвөд угсаатны дэд бүс | Дөрвөд, хотон, баяд угсаатны бүс нутаг: Увс аймгийн Давст, Сагил, Бөхмөрөн, Өмнөговь, Ховд, Өлгий, Тариалан, Наранбулаг, Малчин, Хяргас, Тэс, Зүүнговь сумдын нутаг |
| 4 | | Илжгэн халхчуудын дэд бүс | Цагаанхайрхан, Өндөрхангай, Зүүнхангай сумдын нутаг |
| | | Хотгойдын дэд бүс | Завханы Баянтэс, Тэс, Баянхайрхан, Нөмрөг, Асгат, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан уул, Бүрэнтогтох, Арбулаг, Төмөрбулаг, Тосонцэнгэл, Их-Уул |
| 5 | | Сартуул-Халх дэд бүс | Увс аймгийн Завхан, Завхан аймгийн Сонгино, Түдэвдэй, Цэцэн-Уул, Цамбамаргад, Ургамал, Дөрвөлжин, Зөвхөнммандал, Эрдэнэхайрхан, Яруу |
| 6 | | Дархадын дэд бүс | Хөвсгөл аймгийн Цагаан нуур, Ринчинлхүмбэ, Улаан-Уул, Баянзүрх |
| 7 | | Хар-Ус нуурын олон угсаатны дэд бүс | Ховд аймгийн Эрдэнэбүрэн /Өөлд, мянгадууд/ Дөргөн /Дөрвөд/, Буянт /Мончуу урианхай, халх/ Манхан /Захчин/ Чандмань /Халхчууд/ Зэрэг /Захчин/, Мөст /Халх, захчин/ |
| 8 | | Алтан Өвөрийн торгууд, захчины дэд бүс | Ховын Булган сум /Торгуудууд/ Алтан, Үенч /Завчин/ |
| 9 | Төвийн буюу Халхчуудын дэд бүс | Хангайн нурууны хойд дэд бүс | Халхчуудын дэд бүс: Хөвсгөл, Архангай, Өвөрхангай аймгийн хойд сумдууд |
| 10 | | Дархан-Сэлэнгийн дэд бүс | Халх, казак, дөрвөд угсаатны дэд бүс |
| 11 | Говийн бүс | Палеонтлоги, байгалийн дэд бүс | Өмнөговь аймгийн хойд хагас |

| | | | |
|---|---|---|---|
| 12 | | Говийн байгалийн дэд бүс | Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Говьсүмбэр, Дундговь, Өвөрхангай аймгийн урд сумдууд |
| 13 | Зүүн дэд бүс | Дарьгангын дэд бүс | Сүхбаатар аймгийн Асгат, Халзан, Хонгор, Наран, Онгон, Дарьганга сумдын нутаг |
| 14 | | Буриад угсаатны дэд бүс | Дорнод аймгийн Баяндун, Дашбалбар, Баян-Уул, Цагаан-Овоо, Хэнтий аймгийн Дадал, Дэлгэр, Батширээт |

***Б. Брэнд бүтээгдэхүүн, эвентүүд***

*Хүснэгт №17. Эдийн засгийн үндсэн 5 бүс нутаг дахь нүүдлийн эвент арга хэмжээнүүд*

| № | Эвент төрөл / Бүсүүд | Тайлга, тахилга | Наадам | Урлаг соёлын төрөлжсөн наадам | Бусад чиглэлийн эвент |
|---|---|---|---|---|---|
| 1 | **Баруун бүс** | | 3 | 7 | 7 |
| 2 | **Хангайн бүс** | | 2 | 10 | 10 |
| 3 | **Төвийн ба Говийн бүс** | 2 | 3 | 3 | 2 |
| 4 | **Зүүн бүс** | 1 | 1 | 3 | 4 |
| 5 | **Улаанбаатарын бүс** | 1 | 2 | 4 | 1 |

## 1.4 Нүүдлийн аялал жуулчлал хөгжих нөөц боломж ба хэрэглэгчийн судалгаа:

### 1.4.1 Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх түүх соёлын нөөц, боломж

Тухайн улс үндэстний оюун ухаан, хүч хөдөлмөр шингэсэн түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах түүх, соёл, шинжлэх ухааны үнэ цэнэ, ач холбогдол бүхий түүх, соёл урлаг, археологи, архитектур, байгаль түүхийн дурсгалт газар, угсаатны зүйн дурсгал зэрэг эд өлгийн болон оюуны үнэт зүйлсийг хамарсан өргөн ойлголтыг бид соёлын өв гэж нэрлэдэг.

Өөрөөр хэлбэл, аливаа үндэстэн, угсаатны газар нутаг, байгаль орчиндоо зохицон амьдрах арга ухаан, хэлбэр хэрэгслийн тогтолцоо болж бүтээгдсэн үнэт зүйлс нь нийгэм, түүх, цаг хугацааны шалгуурыг давж өвлөгдсөнийг соёлын өв гэж ойлгох хандлага түгээмэл байна.

НҮБ-ийн Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын Байгууллага (ЮНЕСКО)-гийн 1970 онд Парис хотноо хуралдсан Ерөнхий бага хурлын 16 дугаар чуулганаар баталсан “Соёлын үнэт зүйлийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай” конвенцид “...Соёлын үнэт зүйлс нь ард түмнүүдийн соёл, иргэншил, соёлын үндсэн хэсгүүдийн нэг мөн бөгөөд **гарал үүсэл, түүх, орчин тойрон** нь жинхэнэ үнэ цэнийг нь тодорхойлж байдаг...” хэмээгээд “Соёлын үнэт зүйлс нь археологи, түүхийн өмнөх үе, уран зохиол, урлаг, шинжлэх ухааны ач холбогдолтой гэж улс бүр үнэлж байгаа шашны буюу шашны бус шинж чанартай дор дурьдсан ангилалд хамраарагдах зүйлийг хэлнэ” гэж заажээ.[9]

1. Ургамал, амьтан, эрдэс, цогцсын ховор дээжис, цуглуулга болон палеонтологийн ач холбогдолтой зүйлс
2. Түүхийн үнэт зүйлс, тухайлбал, шинжлэх ухаан, техник, дайн нийгмийн түүх, түүнчлэн үндэстний нэрт зүтгэлтнүүд, сэтгэгчид, эрдэмтэд, жүжигчид болон үндэсний томоохон үйл явдалд холбоотой зүйлс
3. Археологийн олдворууд (жирийн болон далд) болон археологийн нээлтүүд

[9] Stop the illicit traffic of cultural property, UNESCO, 1970

4. Урлагийн болон түүхийн хөшөө дурсгал, археологийн ач холбогдол бүхий газрын бүрэлдэхүүн хэсгүүд
5. 100 жилээс өмнөх үеийн бичээс, цутгамал эд зүйл, зоос, тамга тэмдэг зэрэг хуучны эд юмс
6. Угсаатны зүйн материалууд
7. Урлагийн үнэт зүйлс (гар аргаар үйлдсэн бүх төрлийн уран зураг, уран баримал, сийлбэр, бар, цутгамлууд, уран сайхны сонгомж, эвлүүлэг)
8. Ховор гар бичмэлүүд, хэвлэмэл зүйлс, түүх, урлаг, шинжлэх ухаан, уран зохиол зэрэг онцгай сонирхол татаж байгаа баримт бичиг, хэвлэл гарц нэгээрээ буюу цуглуулга
9. Шуудангийн марк, татварын марк, түүнтэй ижил төстэй маркнууд ганц нэгээрээ буюу тэдгээрийн цуглуулга
10. Дууны бичлэг, гэрэл зургийн, киноны болон бусад архивууд
11. 100 жилийн өмнөх үеийн эртний модон эдлэл, хөгжмийн зэмсгүүд.

Дэлхий дээрх бүх өвийг байгалийн, соёлын, нийлмэл өв гэж ангилаад, соёлын өвийг дотор нь биет болон биет бус өв, дурсгал гэж ангилдаг. [10]

**А. Соёлын биет өв, дурсгал:**

Үндэстэн, угсаатан, газар нутаг, байгаль орчиндоо зохицон амьдрах арга ухаан, хэлбэр хэрэгслийн тогтолцоо болж бүтээгдсэн үнэт зүйлс нийгэм, түүх, цаг хугацааны шалгуурыг дааж өвлөгдсөнийг соёлын өв гэж ойлгох хандлага түгээмэл байна. [11]

***<u>Соёлын биет өв</u>*** гэж түүхэн тодорхой орон зай, цаг үеийг төлөөлөн биетээр оршин байгаа дурсгалыг хэлнэ. Түүнчлэн унаган газартаа хүрээлэн байгаа орчны хамт үнэ цэнэ, ач холбогдол нь илэрхийлэгдэх дурсгалыг Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл гээд, харин тодорхой орон зайд шилжүүлэн байрлуулах боломжтой дурсгалыг Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл хэмээн ялган нэрлэдэг.

1972 онд НҮБ-ийн Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллагын /ЮНЕСКО/ Ерөнхий бага хурлын 17 дугаар чуулганаар баталсан “Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах конвенци”-д “Соёлын өв” гэдэг ойлголтыг үл хөдлөх гэдэг утгаар нь гурав ангилсан байдаг. Үүнд:

**Хөшөө дурсгал** (түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд нэрд гарсан, бүх талын үнэт ач холбогдол бүхий уран барилга, сүрлэг чимэглэлийн уран баримал, уран зургийн бүтээл, археологийн олдвор, бичээс, агуй болон цогцолбор дурсгал)

**Архитектурын чуулга** (түүх, урлаг, шинжлэх ухааны хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий салангид буюу нэгдмэл барилга байгууламж, уран барилгын цогцолбор)

**Дурсгалт газар** (хүний болон хүн, байгалийн хамтарсан бүтээлүүд, мөн түүх, гоо зүй, угсаатны судлалын хувьд нэрд гарсан бүх талын үнэт ач холбогдол бүхий археологи, түүхийн дурсгалт газрыг багтаасан бүс нутаг) гэж ангилсан байна.

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 5 дугаар зүйлд, дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлд хамруулна гэж заажээ. Үүнд: /нүүдлийн соёлтой холбоотойг түүвэрлэв/

5.1.1. эртний ургамал, амьтны чулуужсан олдворт газар;
5.1.2. эртний хүний оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соѐлт давхарга;
5.1.3. чулуун зэвсгийн олдворт газар;

---
[10] ICOMOS, 2002
[11] ICOMOS, 2002

5.1.4. хадны зураг, бичээс;
5.1.5. булш, хиргисүүр, оршуулга, тахил, тайлгын байгууламж;
5.1.6. эртний хот суурин, сүм хийдийн үлдэгдэл, архитектурын дурсгал;
5.1.7. хөшөө дурсгал;
5.1.8. эрт цагт ашигт малтмал олборлож, боловсруулж үйлдвэрлэл, газар тариалан
эрхэлж байсан газар, түүнд холбогдох чулуун дурсгал;
5.1.9. тахилгат газар;
5.1.10. түүхэн үйл явдал болсон дурсгалт газар;
5.1.11. бусад түүх, соѐлын үл хөдлөх дурсгал.

Тус хуулийн 6 дугаар зүйлд, дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамруулна. /Нүүдлийн аялал жуулчлалд хамааралтайг нь түүвэрлэв./

6.1.6. археологийн олдвор;
6.1.7. угсаатны хувцас, чимэглэл;
6.1.8. уламжлалт аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг;
6.1.9. угсаатан, ястны уламжлалт хөгжмийн зэмсэг, эд өлгийн зүйл;
6.1.10. уламжлалт тоглоом, наадгай;
6.1.11. уламжлалт шашин, шүтлэгийн холбогдолтой эд өлгийн зүйл;
6.1.12. бичгийн дурсгалт зүйл;
6.1.13. дүрс, дуу авианы баримт;
6.1.16. гэр, сууц, тэдгээрт холбогдох эд өлгийн зүйл;
6.1.17. бусад түүх, соёлын дурсгалт зүйл.

Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалалтын түвшингээр нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хамгаалалттай гэж зэрэглэдэг бол Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийг дараах шалгуурын дагуу хосгүй үнэт, үнэт, энгийн гэж зэрэглэдэг. Үүнд:

- түүх, соёл, урлаг, гоо зүй, шинжлэх ухааны ач холбогдол,
- холбогдох цаг үе,
- дахин давтагдашгүй байдал,
- ур хийц, дэг сургууль зэрэг шалгуур үзүүлэлтүүд байна.

БСШУ-ны сайдын 2015 оны 108 дугаар тушаалаар түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг тооллогыг улс орон даяар зохион байгуулсан. Улаанбаатар хотын 9 дүүрэг, 21 аймгийн 330 сумын нутаг дахь 9537 дурсгалт газрын 86157 үл хөдлөх дурсгалыг тоолсныг төрөл зүйлээр нь ангилбал,[12]

- Булш оршуулгын дурсгал - 67927 /79%/
- Хадны зураг, бичгийн дурсгал - 6796 /8%/
- Тахил тайлгын байгууламж - 4167 /5%/
- Хөшөө дурсгал - 4230 /5%/
- Барилга, архитектурын дурсгал - 2820 /3%/
- Чулуун зэвсгийн дурсгалт газар - 131 /0,15%/
- Палеонтологийн дурсгалт газар - 51 /0,05%/

[12] Г.Энхбат, "Монголын нүүдлийн соёлын биет болон биет бус өвүүд", СӨҮТ, 2017

*Хүснэгт 13. Үл хөдлөх соёлын өвийн бүртгэлийн мэдээлэл*

| Аймгийн нэр | Чулуун зэвсгийн дурсгалт газар | Хадны зураг, бичгийн дурсгал | | Булш оршуулгын дурсгал | | Тахил тайлгын байгууламж | | Барилга, архитектурын дурсгал | | Хөшөө дурсгал | | Үйлдвэрлэлийн ул мөр хадгалсан дурсгалт газар | Палеонтологийн дурсгалт газар | Нийт дурсгалт газар | Нийт дурсгал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ДГ | Д | ДГ | Д | ДГ | Д | ДГ | Д | ДГ | Д | | | | |
| Архангай | | 37 | 23 | 92 | 2674 | 32 | 65 | 42 | 125 | 111 | 142 | | | 314 | 3029 |
| Баян-Өлгий | 36 | 26 | 29 | 432 | 4018 | 71 | 443 | | | 259 | 624 | | | 824 | 5150 |
| Баянхонгор | 7 | 48 | 5320 | 99 | 1767 | 74 | 172 | 50 | 115 | 79 | 162 | 3 | 2 | 362 | 7548 |
| Булган | 2 | 139 | 165 | 205 | 2645 | 15 | 16 | 52 | 52 | 99 | 177 | 1 | | 513 | 3058 |
| Говь-Алтай | 3 | 90 | 105 | 821 | 5131 | 61 | 80 | 42 | 45 | 113 | 261 | 1 | 3 | 1134 | 5629 |
| Говьсүмбэр | | 1 | 1 | 33 | 284 | 8 | 8 | 5 | 5 | 8 | 8 | | | 55 | 306 |
| Дархан-Уул | | 5 | 5 | 20 | 318 | 2 | 3 | 23 | 23 | 3 | 5 | | | 53 | 354 |
| Дорноговь | 1 | 35 | 46 | 166 | 750 | 99 | 111 | 96 | 1597 | 13 | 18 | 3 | 18 | 431 | 2544 |
| Дорнод | 10 | 4 | 7 | 108 | 2020 | 18 | 103 | 92 | 117 | 17 | 40 | 2 | | 251 | 2299 |
| Дундговь | 2 | 36 | 37 | 151 | 1392 | 63 | 65 | 44 | 44 | 6 | 7 | 1 | 3 | 306 | 1551 |
| Завхан | | 93 | 101 | 314 | 6995 | 113 | 616 | 34 | 36 | 175 | 1186 | | | 729 | 8934 |
| Орхон | | | | 28 | 343 | | | 5 | | 6 | 11 | | | 39 | 354 |
| Өвөрхангай | 4 | 50 | 118 | 314 | 6165 | 70 | 147 | 57 | 60 | 60 | 114 | 7 | 4 | 566 | 6619 |
| Өмнөговь | 1 | 51 | 51 | 43 | 2148 | 24 | 24 | 62 | 62 | 13 | 13 | 3 | 16 | 213 | 2318 |
| Сүхбаатар | 27 | 21 | 20 | 97 | 1157 | 42 | 42 | 50 | 63 | 39 | 97 | 1 | | 277 | 1407 |
| Сэлэнгэ | 4 | 20 | 44 | 240 | 2861 | 3 | 3 | 25 | 35 | 47 | 52 | 4 | | 343 | 3003 |
| Төв | | 21 | 178 | 227 | 2895 | 43 | 1397 | 71 | 106 | 26 | 92 | 1 | | 389 | 4669 |
| Увс | | 79 | 86 | 162 | 1573 | 17 | 17 | 4 | 6 | 202 | 395 | 0 | 1 | 464 | 2077 |
| Ховд | - | 92 | 307 | 305 | 5947 | 61 | 237 | 35 | 35 | 88 | 484 | 3 | 5 | 589 | 7018 |
| Хөвсгөл | 2 | 72 | 91 | 485 | 10721 | 23 | 34 | 25 | 24 | 91 | 207 | 2 | | 700 | 11081 |
| Хэнтий | 32 | 58 | 59 | 551 | 5776 | 113 | 580 | 124 | 148 | 104 | 132 | 3 | | 985 | 6730 |
| Улаанбаатар | | 3 | 3 | 60 | 347 | 5 | 4 | 146 | 122 | 3 | 3 | | | 217 | 479 |
| **Нийт дурсгалт газар** | | **981** | | **4953** | | **957** | | **1084** | | **1562** | | | | **9537** | |
| **Нийт дурсгал** | **131** | | **6796** | | **67927** | | **4167** | | **2820** | | **4230** | **35** | **51** | | **86157** |

ДГ- Дурсгалт газар
Д- Дурсгал

*Диаграмм 1. Түүх соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогын үр дүн*




Нийт 26 байгууллагын 777 **хосгүй үнэт дурсгал** батлагдсаныг төрөл зүйлээр ангилвал,

- Түүхийн холбогдолтой эд өлгийн зүйл - 402

- Шашин шүтлэгийн холбогдолтой дурсгал - 273
- Археологийн олдвор - 48
- Байгалийн дурсгал - 34
- Урлаг, уран сайхан - 11
- Угсаатны зүйл, эд өлгийн дурсгал - 8

*Диаграмм 2. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалын төрөл зүйл*




**Монгол Улсаас дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн дурсгалууд**

ЮНЕСКО-ийн Дэлхийн өвийн хорооноос манай улсын Орхоны хөндийн соёлын дурсгалт газрыг 2004 онд, Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолборыг 2011 онд хүн төрөлхтний соёл, иргэншлийн түүхийн олон улбааг хадгалсан дурсгалтай, тэдгээр нь дэлхий дахинд нийтлэг үнэ цэнэтэй гэж үзэн дэлхийн соёлын өвд бүртгэн авсан байна.

Орхоны хөндийн соёлын дурсгалт газар нь 121,967 га газрыг хамардаг бөгөөд энэ бүс нутагт 100 гаруй дурсгалт газарт 1350 орчим нэгж ширхэг түүх, соёлын үл хөдлөх дурсгал оршдог байна. Эдгээр дурсгалын дотор өмнө нь улс, аймгийн хамгаалалтад орж байсан цөөнгүй дурсгал хамрагдсан юм.[13]

**Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлс**

Монгол Улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8-р зүйлд заасны дагуу дагуу соёлын өвийг түүх, соёл, урлаг, гоо зүй, шинжлэх ухааны ач холбогдол, холбогдох цаг үе, дахин давтагдашгүй байдал, ур хийц дэг сургууль зэрэг шалгуур үзүүлэлтээр нь “хосгүй үнэт”, “үнэт”, гэж зэрэглэдэг.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 1995-2013 онуудад байгалийн түүх, палеонтологи, археологи, түүх, угсаатны зүй, урлаг уран сайхан, бурханы шашны төрөл зүйлд хамаарах 776 үзмэр, эд өлгийн зүйлийг “Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл”-ийн зэрэглэлд батлагдсан байна.[14]

**Соёлын өвийн төвийн Улсын нэгдсэн бүртгэл мэдээллийн санд хадгалагдаж буй түүх, соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэлийн жагсаалт**:

БСШУЯ-ний харьяа Соёлын өвийн төв нь Монгол Улсын Сангийн сайд, Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн сайдын 2006 оны 09-р сарын 27-ны өдрийн 299/324/111 тоот хамтарсан тушаалаар “Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл болох булш, хиргисүүр, хадны зураг, бичээс, хөшөө чулуу, сүм хийд, түүний үлдэгдэл, эртний хотын туурь, түүхт овоо суврага зэргийг

[13] Соёлын өвийн үндэсний төвийн соёлын биет бус өвийг хадгалаж хамгаалах хэтийн чиг хандлага статистик мэдээ. А.Саруул СББӨ-ийг хамгаалах хэлтсийн дарга

[14] О.Сүхбаатар ба бусад “Монгол улс дэлхийн нүүдлийн соёл аялал жуулчлалын төв болох нь” ЭШӨ 2017 УБ

бүртгэн тоолох" ажлыг 2008 оноос эхлэн хэрэгжүүлж 2013 оны байдлаар 14 аймгийн 175 сумын нутаг дэвсгэрт байрлах Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын холбогдох анхан шатны бүртгэл, жагсаалтыг хийсэн байна.

- 2008 онд Хэнтий, Сүхбаатар,
- 2009 онд Дорнод, Дорноговь, Говьсүмбэр,
- 2010 онд Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон, Булган,
- 2011 онд Өвөрхангай, Дундговь
- 2012 онд Төв, Архангай
- 2013 онд Завхан аймгийн нутагт ажиллаж 2750 орчим дурсгалт газрын дурсгалыг бүртгэн баримтжуулж, холбогдох мэдээллийг Улсын нэгдсэн бүртгэл- мэдээллийн сан болон нэр дурдсан аймгуудын бүртгэл-мэдээллийн санд хадгалаад байна.

2017 оны байдлаар Түүх соёлын үл хөдлөх дурсгалын үзлэг, тооллогод 21 аймгийн 331 сум, нийслэлийн 9 дүүрэг хамрагдсан байна. Дүн мэдээгээр авч үзвэл 9537 дурсгалт газрын 86157 ширхэг үл хөдлөх дурсгал бүртгэгдсэн байна.[15]

**Түүх соёлын үл хөдлөх дурсгалтай холбогдох хууль, журмын тухай.**

Монгол улсын үндсэн хууль: 7.1-д Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна

- Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал: 3.1.4.1-д Монголын түүх, хэл, соёл, шашин, зан заншлыг хамгаалах, хөгжүүлэх, судлах ажлыг төр ивээлдээ авч, ном, сурах бичиг, кино урлагийн бүтээл туурвилыг онцгойлон урамшуулж, биет болон биет бус соёлын өвийг хамгаалан хөгжүүлнэ.
- Монгол Улсын Төрөөс баримтлах соёлын бодлого: 4.3.2-д Эрт эдүгээгийн соёлын өв санг үндэсний эрхэм баялаг болохын хувьд төрийн хамгаалалтад байлгах
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль
- Соёлын тухай хууль
- Археологийн малталт судалгаа хийх журам[16]

**Б. Соёлын биет бус өв, дурсгал**

Соёлын биет бус өв гэдэг нь конвенцийнхоо дагуу тухайн орон нутгийн ард иргэд, бүлэг хүмүүс өөрийн мэдлэг, дадал, заншил, ёс гэж хүлээн зөвшөөрсөн зүйлсийг хэлнэ гэж заасан байдаг. Биет бус өвийг конвенцид зааснаар тав хуваасан байдаг. Үүнд: Эх хэл түүнтэй холбогдуулан утга уран зохиолын аман хэлбэрүүд, ардын аман зохиол, ардын язгуур урлаг, гар урлал, байгаль сав шим ертөнцийн тухай мэдлэг, арга ухаан гэж тав хуваасан байдаг. Өөрөөр хэлбэл соёлын биет бус өв гэдэг нь Монгол арга ухаан, Монгол хүний оюунаар бүтээгдсэн бүхий л зүйлийг хэлнэ.[17]

Үеэс үед уламжлагдах соёлын биет бус өвийг хамт олон, бүлэг хүмүүс нь тэдгээрийг хүрээлэн буй орчин, байгаль, түүхийн харилцан шүтэлцээнээс шалтгаалан байнга шинэчилдэг бөгөөд тухайн өв нь тэдгээрт оршин тогтнох болон залгамж чанарын мэдрэмж төрүүлж, соёлын төрөл зүйл, хүний туурвилыг хүндэтгэхэд дэмжлэг үзүүлдэг. Энэхүү конвенцийн зорилгод олон олон улсын хүний эрхийн зөвхөн одоо мөрдөж буй баримт бичиг болон хамт олон, бүлэг, хувь хүмүүсийн хоорондын харилцан хүндэтгэл, мөн тогтвортой хөгжлийн шаардлагуудад нийцсэн соёлын биет бус өвийг авч үзнэ.

Соёлын биет бус өвийг хамгаалах 2003 оны Конвенц батлагдсанаас хойш 170 орон, түүний дотор Зүүн хойд Азийн дараах таван улс хамрагджээ. Үүнд: Япон, БНХАУ, Өмнөд Солонгос, Хойд Солонгос, Монгол орж байна. Зүүн хойд Ази нь түүхэн урт удаан

---

[15] О.Сүхбаатар ба бусад "Монгол улс дэлхийн нүүдлийн соёл аялал жуулчлалын төв болох нь" ЭШӨ 2017 УБ
[16] www.legalinfo.mn
[17] О.Сүхбаатар ба бусад "Монгол улс дэлхийн нүүдлийн соёл аялал жуулчлалын төв болох нь" ЭШӨ 2017 УБ

хугацааны турш соёлын асар баялаг өв уламжлалыг бүтээж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд СББӨ-ийг хамгаалах талын бодлогоороо манлайлж байна.

Дэлхийн хэмжээнд нийт 391 соёлын биет бус өв бүртгэгдсэнээс 93 нь Зүүн хойд Азиас бүртгэгдсэн байна. Үүнээс Япон улс 22, Хятад улс 38, Өмнөд Солонгос 18, Хойд Солонгос 2, Монгол Улс 13-г тус тус бүртгүүлжээ.

**Монгол Улсын СББӨ-ийн тоон тойм мэдээ:**

*Монгол Улсын СББӨ-ийн Үндэсний жагсаалтанд 201 өв бүртгэлтэй:*

- Төлөөллийн жагсаалт–80
- Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалт–16
- СББӨ-ийг ур чадварын өндөр түвшинд өвлөн уламжласан билиг авьяастны жагсаалт–105

*ЮНЕСКО-гийн СББӨ-ийн жагсаалтанд 13 өв бүртгэлтэй:*

- Төлөөлийн жагсаалт -7
- Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ-ийн жагсаалт – 6

**Соёлын биет бус өв:**

*Хүснэгт 14. Соёлын биет бус өвийн тоо*

| № | Засаг захиргааны нэгж | | 2010 он | 2011 он | 2012 он | 2013 он | 2014 он | 2015 он | 2016 он | Нийт өвлөгчийн тоо |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Бүртгэлд хамрагдсан өвлөгчийн тоо | | | | | | | |
| 1 | 21 аймаг | 330 сум | 2848 | 1292 | 1052 | 680 | 568 | 123 | 30 | **6593** |
| 2 | 9 дүүрэг | 152 хороо | 583 | 656 | 0 | 108 | 81 | 30 | 15 | **1473** |
| Нийт | | | 3431 | 1948 | 1052 | 788 | 649 | 153 | 45 | **8066** |

*Хүснэгт №15. ЮНЕСКО-д бүртгэдсэн Монголын соёлын өвийн жагсаалт*

| № | Бүртгэгдсэн огноо | Биет бус соёлын өв |
|---|---|---|
| 1 | 2004 он | Орхоны хөндийн соёлын дурсгалт газар** |
| 2 | 2008 он | Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг |
| 3 | | Монгол ардын уртын дуу |
| 4 | 2009 он | Монгол тууль* |
| 5 | | Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг* |
| 6 | | Монгол бий биелгээ, уламжлалт бүжгийн урлаг* |
| 7 | 2010 он | Монгол наадам |
| 8 | | Монгол ардын Хөөмэйн урлаг |
| 9 | | Шувуучлахуй буюу бүргэдээр ан хийх зан үйл |
| 10 | 2011 он | Монгол Лимбэчдийн уртын дуу тоглох уламжлалт арга барил –битүү амьсгаа* |
| 11 | | Алтан товч ** |
| 12 | | Монгол Данжуур** |
| 13 | | Монгол Алтайн нурууны хадны зургийн цогцолбор** |
| 14 | 2013 он | Монгол гэрийн уламжлалт урлал, зан үйл |
| 15 | | Монгол уран бичлэг* |
| 16 | 2014 он | Шагайн харваа |
| 17 | 2015 он | Ботго авахуулах зан үйл* |

* Яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өв

** Соёлын биет өв

**Яаралтай хамгаалах шаардлагатай СББӨ –ийн жагсаалт:**

1. Уламжлалт бүжиг- бий биелгээ-2009 он
2. Монгол тууль-2009 он

3. Монгол цуур хөгжмийн уламжлалт урлаг-2009 он
4. Монголын лимбэчдийн уртийн дуу тоглох уламжлалт арга барил битүү амьсгаа-2011 он
5. Монгол уран бичлэг 2013 он
6. Ботго авахуулах зан үйл 2015 он

**СӨҮТ-ийн архивт хадгалагдаж буй СББӨ-ийн материалууд:**

- 400 цагийн дуу бичлэг
- 10050 цагийн дүрэс бичлэг
- Давхардсан тоогоор 1200 хүний дуу, дүрс бичлэг, гэрэл зургууд хадгалагдаж байна[18].

**СББӨ-ийн уламжлагдаж хадгалагдсан тархалт нутаг:**

**Ерөөл:** Хөвсгөл, Архангай, Завхан, Баянхонгор, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Булган, Төв, Өмнөговь, Өвөрхангай, Дундговь, Хэнтий соёлын голомт нутаг юм.

Эдгээр аймагт нүүдэлчдийн соёлыг харуулсан гэр барих, мал хөнгөлөх, бэр гуйх ёсыг үзүүлэх тайлбарлан таниулах соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тохиромжтой юм.

**Магтаал:** Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Архангай, Завхан, Говь-Алтай, Ховд, Увс, Баян-Өлгий, Өвөрхангай, Сүхбаатар, Дорноговь, Говьсүмбэр уламжлагдан иржээ.

Эдгээр аймагт гэр барих, мал хөнгөлөх, бэр гуйх, эсгий хийх, сур элдэх зэргийг харуулсан соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх нүүдэлчдийн дунд одоог хүртэл ам дамжигдан ирсэн магтаалыг сонирхон судлах боломжтой юм. Тэмээ, морь, үхэр тэргээр нүүх нүүдлийн ахуйн соёлыг хадгалагдаж үлджээ.

**Уртын дуу:** Булган, Сэлэнгэ, Архангай, Өвөрхангай, Баянхонгор, Дундговь, Говьсүмбэр, Сүхбаатар. Эдгээр аймгуудад уртын дууны эвент зохин байгуулах, соёлын аялал жуулчлалын нөөцийн үнэт өв уртын дуу, морин хуур соёл хамгийн их дэлгэрсэн нутаг юм.

**Хөөмэй:** Завхан, Увс, Баян-Өлгий, Өвөрхангай, Баянхонгор, Архангай, Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Дорнод, Дорноговь өв уламжлан ирсэн нутаг юм.

**Бие Биелгээ:** Сэлэнгэ, Булган, Төв, Ховд, Баян-Өлгий.

**Лимбэ:** Сэлэнгэ, Өвөрхангай, Ховд, Завхан, Говь-Алтай.[19]

*Зураг 11. Соёлын биет болон биет бус өвийн тархалтыг зургаар харуулбал:*




---

[18]Соёлын өвийн үндэсний төвийн соёлын биет бус өвийг хадгалаж хамгаалах хэтийн чиг хандлага статистик мэдээ. А.Саруул СББӨ-ийг хамгаалах хэлтсийн дарга

[19] Соёлын өвийн үндэсний төвийн соёлын биет бус өвийг хадгалаж хамгаалах хэтийн чиг хандлага статистик мэдээ. А.Саруул СББӨ-ийг хамгаалах хэлтсийн дарга.

Энд цагаан баганаар Улсын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн соёлын биет өв, үзмэрүүдийн тоог, шар баганаар тус бүртгэлд бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт газруудын тоог, улаан баганаар “Нүүдэлчин Монгол” СББӨ-н наадамд бүртгэгдсэн биет бус өвийн тоог тус тус илэрхийлж байна. Эндээс харахад, баруун бүс нутагт биет үзмэрүүд, түүх, соёлын дурсгалт газрууд их байгаа нь харагдаж байна.

Харин биет бус өвийн бүртгэлийн хувьд, зурагт харьцангуй нарийн тодорхой тусгагдаагүйн дээр анх удаа зохиогдсон тус наадамд газарзүйн байрлалаасаа шалтгаалан төвийн бүсийнхэн илүү идэвхитэй оролцсон байх талтай гэж таамаглаж байна.

СББӨ-ийн таван ай саваас өнөөдөр аялал жуулчлалд хамгийн түгээмэл ашиглагддаг нь:

- Ардын язгуур урлаг /урлагийн тоглолтууд/
- Баяр наадам, фестиваль, мал ахуйтай холбоотой зан үйлүүд /эвентүүд/, ёслолууд /овоо тахилга/,
- Ардын уламжлалт гар урлал /бэлэг дурсгал, сувинер/ зэрэг байна.

Эцэст нь, Нүүдлийн аялал жуулчлалын үндсэн нөөц бол СББӨ, түүнийг өвлөн уламжлагч нүүдэлчин ард түмэн, нутгийн иргэд юм.

### ***1.4.2. Нүүдлийн аялал жуулчлалыг сонирхогч жуулчны зах зээл, хэрэглэгчийн судалгаа***

Монгол улсад аялаж буй гадаадын жуулчдын “Нүүдлийн аялал жуулчлал”-ын талаарх сэтгэгдэл, үнэлгээг судлаж үзэх нь энэ талаарх цаашдын бодлого, төлөвлөлтөнд чухал үүрэгтэй юм. Энэхүү судалгааг АЖҮТ, НАЖГ, МУИС-ийн хамтран хийсэн “Улаанбаатар хотод аяласан гадаадын жуулчдын сэтгэл ханамжийн судалгаа-2015” /Монгол улсад 2012 онд аялсан гадаадын жуулчдад явуулсан судалгааны арга зүйд тулгуурласан/ болон Монгол банкнаас 2017 онд хийсэн “Монгол улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа” зэрэг судалгааны мэдээлэл дээр үндэслэн түүвэрлэж авсан болно.

**“Монгол улсад аялсан гадаадын жуулчдад явуулсан судалгаа”-нуудын харьцуулсан үр дүнгээс: /2002, 2005, 2012, 2015/**

Монгол улсад аялан ирж байгаа гадаадын жуулчдын тухай, тэдний ерөнхий төлөв байдал, аялалын хэлбэр, зарцуулсан зардал, санал сэтгэгдлийг судлах зорилгоор анх 1998 онд ТАСИС, 2002 онд МАЖХ/ӨЧС, 2004 онд АЖГ, 2012 онд БОАЖЯ, 2015 онд АЖТХТ-өөс тус тус судалгааг хийсэн билээ.

2002, 2005, 2012, 2015 судалгаануудын үр дүнгээс “Нүүдлийн аялал жуулчлал”-тай холбогдох үр дүнг нэгтгэн авч үзвэл дараах байдалтай байна.

*Хүснэгт №18. Чөлөөт цагаа өнгөрүүлэх, амрах, алжаалаа тайлах шалгаанаар Монголыг сонгох болсон үндсэн шалтгаан 2004, 2012, 2015 он (%)*[20]

| Монголыг сонгох болсон шалтгаан | 2004 | 2012 | 2015 |
|---|---|---|---|
| Байгалийн гоо үзэсгэлэнг сонирхох | 53 | 60.7 | 70.3 |
| Зэрлэг ан амьтан сонирхох | 20 | 9.4 | 20.5 |
| Нүүдлийн соёл, иргэншил сонирхох | 35 | 42.8 | 47.2 |
| Монголын түүх танилцах | 16 | 11.3 | 31.5 |
| Адал явдал, морь унах, явган аялал, дугуйн аялал хийх | 19 | 12.1 | 27.7 |
| Баяр наадам, үйл явдал сонирхох | 5 | МВ | 35.2 |
| Ан хийх, загасчлах | 1 | 1.9 | 1.5 |
| Бусад галтгаан | 4 | 12.4 | 21 |

[20] НАЖГ “Улаанбаатар хотод аялсан гадаадын жуулчдын сэтгэл ханамжийн судалгаа” 2015 он УБ




*Хүснэгт 20. Чөлөөт цагаа өнгөрүүлэх, амрах, алжаалаа тайлах шалтгаанаар Монголыг сонгох болсон үндсэн шалтгаан. 2004, 2012, 2015 оны харьцуулалт*

| Монголыг сонгох болсон шалтгаан | 2004 | 2012 | 2015 |
|---|---|---|---|
| Байгалийн гоо үзэсгэлэн сонирхох | 53 | 60.7 | 70.3 |
| Зэрлэг ан амьтан сонирхох | 20 | 9.4 | 20.5 |
| Нүүдлийн соёл, иргэншил сонирхох | 35 | 42.8 | 47.2 |
| Монголын түүх танилцах | 16 | 11.3 | 31.5 |
| Адал явдал, морь унах, явган аялал, дугуйн аялал хийх | 19 | 12.1 | 27.7 |
| Баяр наадам, үйл явдал сонирхох | 5 | М/Б | 35.2 |
| Ан хийх, загасчлах | 1 | 1.9 | 1.5 |
| Бусад шалтгаан | 4 | 12.4 | 21 |

*Диаграмм 3. Жуулчдын нүүдлийн соёлын үйлчилгээний талаарх үнэлгээ*




**“Монгол улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа”-ны хэсгээс:**

Төлбөрийн тэнцлийн статистикт аялал жуулчлалын салбарын орлогыг тооцоход ашиглагдах гадаадын жуулчдын дундаж зардлын хэмжээг тодорхойлох зорилгоор Монгол Улсад аялсан нийт 55 орны 1543 гадаадын жуулчид, аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулдаг 41 аж ахуй нэгжээс 2019 онд Монгол банк, Аялал жуулчлалын Хөгжлийн төв-ийн хамтран явуулсан судалгааны дүн болон өмнөх 2017 онд хийсэн судалгаатай харьцуулан “Нүүдлийн аялал жуулчлал”-тай холбоотой мэдээллийг нэгтгэж үзлээ.

Хүснэгт 5. **Гадаадын жуулчдын Монголд ирээд хийж үздэг зүйлс**[21]

[21] Монгол банк, АЖХТ “Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд” 2019 он. 18ху

| | Монголд ирэхээс өмнө хийхийг хүсч байсан | Хийж үзээд сэтгэл хангалуун байна | Дараа ирэхдээ хийж үзнэ |
|---|---|---|---|
| Зэрлэг, онгон байгаль | 256 | 290 | 254 |
| Байгальд алхах | 188 | 207 | 207 |
| Морь унах | 243 | 253 | 204 |
| Монгол хоол идэх | 237 | 271 | 161 |
| Дэлгүүр | 174 | 201 | 120 |
| Музей, үзвэр | 141 | 173 | 135 |
| Соёл | 218 | 209 | 170 |
| Наадам | 144 | 80 | 236 |
| Спорт | 90 | 73 | 174 |
| Гэр | 234 | 300 | 175 |
| Дуу | 174 | 218 | 156 |
| Чингис Хаан | 146 | 111 | 121 |
| Бусад | 22 | 18 | 19 |

Монголд аялаж байхдаа хийсэн зүйлсээс хамгийн их сэтгэлд таалагдсан зүйлсийг асуухад гэрт байрлах, байгальд аялах, морь унах, Монгол хоол идэх зэргийг онцолжээ. Монгол улсад ирэхээс өмнө тэр бүр төсөөлөөгүй боловч маш өндөр сэтгэгдэл үлдээдэг бусад зүйлд музей, үзвэрийн газраар зочлох, ардын урлагийн тоглолт үзэх болон дэлгүүрт худалдан авалт хийхийг нэрлэсэн байна.

Нийт ирсэн жуулчдын дийлэнх нь байгалийн үзэсгэлэнт байдалд сэтгэл хангалуун байдаг гэжээ. Үүний дараа морь унах, гэрт байрлахыг онцолсон байна. Монгол хоол идэж үзэхийг тун өндөр ач холбогдолтой гэж үзжээ. Монголын соёлтой танилцахад мөн адил өндөр ач холбогдол өгсөн байна.

***Диаграмм №03.*** 2017 онд ирсэн гадаадын жуулчдын Монгол улсад ирсэн аяллын зорилго[22]




Монгол орныг зорин ирэх жуулчдын 30-68% нь нүүдлийн соёл, уламжлал, мал аж ахуй, ахуй амьдралтай танилцах зорилгоор ирдэг. Нүүдэлчдийн соёл, уламжлалтай танилцах зорилгоор өндөр хөгжилтэй улс орнууд АНУ, Япон, Европын улс орнуудаас ихэвчлэн жуулчид ирдэг байсан бол 2015 оноос БНХАУ, БНСУ-ын жуулчид группээрээ аялах нь нэмэгдэж байна.

**Аяллын сэтгэл ханамж**

2019 оны судалгаанд хамрагдагсдын 79% нь Монголд байсан хугацааныхаа сэтгэл ханамжийг  аюулгүй байдал, хүмүүсийн хандлага, тур оператор ба агентын гүйцэтгэл, байр сууц, хоол, газрын тээвэр, зочлох газрууд, үйлчилгээний ажилтнууд гэсэн дараалаар 1-4 оноогоор үнэлж, судалгаанд оролцсон үр дүнгээс дурьдахад “Монголд бүрэн дүүрэн сэтгэл хангалуун байгаа” гэж **38%** хариулжээ. Харин 56% нь хүлээлтээс арай дээр буюу

[22] Монгол банк “Монгол улсад аялж буй гадаадын жуулчдын зардлын түүвэр судалгаа” 2017 он

дунд зэрэг гэж үнэлсэн бол 5% нь хүлээлтээс доор хангалтгүй байсан, 1% нь хүлээн зөвшөөрөхийн аргагүй, огт хангалтгүй гэсэн үнэлгээг өгсөн байна.[23]

Монгол улсад зорин очсон газартаа 2 хүн тутмын 1 нь маш сайн гэсэн үнэлгээ өгсөн бол тээврийн хэрэгсэл, авто замын байдлын талаар үнэлгээ өгөхдөө 3 хүн тутмын нэг нь хүлээлтээс доор байсан гэжээ. Хоол, үйлчилгээний ажилтнуудад дунджаар 15% нь хүлээлтээс доор гэсэн үнэлгээг өгсөн байна. Монгол улсад аялж байгаа 10 хүн тутмын нэг нь аюулгүй байдалдаа санаа зовниж байсан бол мөн 10 хүн тутмын нэг нь Монгол хүмүүсийн хандлагад сэтгэл дундуур үлджээ.

Хүснэгт 6. Аяллын сэтгэл ханамж

| | Нийт | Аюулгүй байдал | Хүмүүсийн хандлага | Тур оператор, агентын гүйцэтгэл | Байр, сууц | Хоол | Газрын тээвэр | Зочлох газрууд | Үйлчилгээний ажилтнууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Маш сайн | 38% | 34% | 45% | 44% | 29% | 27% | 21% | 48% | 34% |
| Хүлээлтээс арай дээгүүр буюу дунд зэрэг | 56% | 55% | 43% | 46% | 56% | 54% | 43% | 41% | 47% |
| Хүлээлтээс доор | 5% | 11% | 10% | 8% | 12% | 16% | 30% | 9% | 14% |
| Хүлээн зөвшөөрөх аргагүй | 1% | 1% | 9% | 9% | 10% | 10% | 5% | 4% | 3% |

Эдгээр үзүүлэлтийг Монгол банкнаас явуулсан гадаадын жуулчдын зардал тодорхойлох зорилготой өмнөх үеийн судалгаануудтай нь харьцуулан үзүүлбэл дараах байдалтай байна.

*Зураг 13. Монголын уламжлалт зан заншил, соёлыг танин мэдэхээр ирсэн жуулчдын эзлэх хувь*




Цаашид бид Нүүдлийн аялал жуулчлалын зах зээлийг өргөтгөх, жуулчдыг групээрээ нь аялуулах боломжоор хангах шаардлага зүй ёсоор тулгарч байна.Монгол банкнаас явуулсан судалгаагаар нүүдлийн соёл, зан заншлын сонирхож гадаадын жуулчдын улс орноор нь харьцуулвал дараах улс орнуудын жуулчид ноёлож байна.

*Хүснэгт 24. Монголын уламжлалт зан заншил, соёлыг үзэхээр ирсэн жуулчдын эзлэх хувь*

| | АНУ | Австрали | БНХАУ | Франц | Герман | Солонгос | Япон | НВУ | Европын бусад улс орнууд | Бусад орнууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|

[23] Монгол банк, АЖХТ "Аялал жуулчлалын салбарын өнөөгийн байдал, шийдвэрлэх асуудлууд" 2019 он. 20ху

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2012 | 37,8 | 36,1 | 29,3 | 58,8 | 35,1 | 14,1 | 15,2 | 37,7 | 51,5 | 30,5 |
| 2015 | 50,5 | 47,3 | 21,7 | 58,9 | 56,9 | 25,3 | 41,6 | 54,3 | 54,6 | 44,2 |

Судалгаанд хамрагдсан жуулчдаас АНУ, Австрали, Франц, Герман, Солонгос, Япон, НВУ болон бусад улс орнуудын жуулчид өссөн бол зөвхөн БНХАУ-ын жуулчид буурсан үзүүлэлттэй байна.

### 1.5. Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нөөц боломж, өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ /SWOT анализ/

| **Strengths: Давуу тал** | **Weaknesses: Сул тал** |
|---|---|
| Нүүдлийн аялал жуулчлалын хөдлөх болон үл хөдлөх өв дурсгалын нөөц боломж маш их | Аялал жуулчлалын улирал богино |
| Монгол улсын гадаад харилцааны тогтвортой өсөлт, нээлттэй бодлого | Үйлчилгээний байгууллагуудын багтаамж хангалтгүй, жуулчдын шаардлага хангах өндөр зэрэглэлийн үйлчилгээтэй жуулчны бааз, зочид буудлууд дутмаг |
| Монголын нүүдлийн соёл, иргэншил дахин давтагдашгүй, уламжлалт хэв шинжээ хадгалан үлдэж чадсан тул дэлхийн аялал жуулчлалын зах зээлд Монголын гэсэн өвөрмөц шинж төрх, давуу талыг илэрхийлж чаддаг | Нутаг дэвсгэрийн хэмжээ том, авто зам, агаарын тээврийн хангамж муу тул жуулчдын тав тухыг алдагдуулж үзмэр (зорих газар) хооронд цаг их зарцуулж, ядрахад хүргэдэг |
| Монгол улс нь дэлхийн түүхэнд томоохон үүрэг гүйцэтгэсэн агуу гүрний үр сад тул “Эзэн Богд Чингис хаан”, “Их Монгол улс”, “Ил хаадын улс”-ын бахармал түүхтэй юм | Мэргэжлийн боловсон хүчний хангамж сул, иргэдийн аялал жуулчлалын эвент байхгүй, сургалт, маркетинг болон идэвхижүүлэлтийн төлөвлөлт дутмаг байдал |
| Гадаадын жуулчдын зорин ирэх шалтгаан, нүүдэлийн соёл, уламжлалыг хадгалан үлдэх тул | Аймаг бүр өөрийн гэсэн дагнасан нүүдлийн соёл, уламжлал, эвент арга хэмжээ байхгүй |
| Гадаад аялал жуулчлалын урсгал нэмэгдэж буй төвийн бүс ба бусад бүх нүүдэлчдийн соёл уламжлалыг сурталчилах, түгээн дэлгэрүүлэх | Монголчуудын давтагдашгүй нүүдлийн соёл уламжлал, түүхийг дэлхий дахинд аялал жуулчлалын брэнд болгон хангалттай танилцуулж чадахгүй байна |
| **Opportunities: Боломж** | **Threats: Аюул** |
| Монгол улсын засгийн газраас Монгол улсын Нүүдлийн аялал жуулчлалын голлох бүс нутаг болгох зорилгоор олон улсад сурталчлан таниулах ажлыг эрчимтэй хийж байна. | Киргизстан, БНХАУ-ын Өвөр Монгол, Казахстан зэрэг улсууд нь Нүүдлийн аялал жуулчлалын хувьд өрсөлдөгч бөгөөд Олон улсад нүүдлийн соёлын зорин очих газрын нэг болж хөгжиж байгаа байдал |
| Нүүдлийн аялал жуулчлалд дотоодын бизнес эрхлэгч нарын хөрөнгө оруулагчдын сонирхол нэмэгдэж байгаа | Соёлын глобалчлал, технологийн дэвшлийн нөлөөгөөр үндэстэн, угсаатны үнэт зүйл, өв уламжлал мартагдах, хандлага, ялангуяа залуусын дунд нэмэгдэх үзэгдэл |
| Дэлхийн аялал жуулчны байгуулгын судалгаанаас үзэхэд ирэх 50 жил Азийн бүс нутаг, дэлхийн аялал жуулчлалын гол бүс нутаг болох төлөвтэй байна | Уул уурхайн нөхөн сэргээлт муу, газар тариалангийн замбараагүй зөвшөөрөл, алтны цооногоос болж байгаль орчин бохирдож Нүүдлийн аялал жуулчлалын нөөцийг эрсдэлд учруулах байдал, гадаад харилцаа, эдийн засгийн хямрал, валютын ханшны хэлбэлзэл, инфляци тогтворгүй байдал |
| Судалгаанаас үзэхэд жуулчны эрэлт хэрэгцээ, хангах хамгийн ихтэй хүчин зүйл бол байгаль орчин, нүүдлийн соёл, уламжлал | Нүүдлийн соёл, уламжлалыг ашиглан бие даасан болон хямд өртгөөр аялах жуулчдын тоо өсөх |
| Байгалийн гаралтай бүтээгдэхүүн, өрш орнуудын жуулчдыг татах, аялал жуулчлалын зах зээл багтаамж ихтэй тул Inbound аялал хөгжүүлэх боломжтой | Эх газрын эрс тэс уур амьсгал нь аялал жуулчлалыг улирлын шинжтэй болгож хязгаарладаг |

| | |
|---|---|
| Мянганы замын дагуу хатуу хучилттай зам тавих зэргээр дэд бүтцийн шинэ төлөвлөлт, бүтээн байгуулалтыг төвлөрсөн төсөв болон орон нутгийн төсвөөс хийгдэж байгаа байдал | Жуулчны аюулгүй байдалд нөлөөлөх улс төрийн тогтворгүй байдал, цаг агаарын таагүй байдал, шүлхий зэргээс болж аялал хийхэд боломжгүй байдал гарах |

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ГОЛ ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД БА СТРАТЕГИ

### 2.1 НҮҮДЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ МОНГОЛ УЛСАД ХӨГЖҮҮЛЭХ АЛСЫН ХАРАА, ЭРХЭМ ЗОРИЛГО

**Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөний "Алсын хараа":**

Монгол улс нь нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан Нүүдлийн аялал жуулчлалыг тогтвортой хөгжүүлсэн Олон улсын төв болсон байна.

2030 онд:

- Язгуурын нүүдэлчин Монголчуудын Нүүдлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, эвентийг **Олон улсын аялал жуулчлалын зах зээлд брэнд** болгосон
- **Нутгийн иргэдэд тулгуурласан** Нүүдлийн аялал жуулчлалыг тогтвортойгоор хөгжүүлсэн
- Нүүдлийн аялал жуулчлалын **Олон улсын хамгийн том зорих газрын нэг** болсон байх болно.

**Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөний "Эрхэм зорилго":**

Энэхүү төлөвлөгөө нь Язгуурын нүүдэлчин Монголчуудын түүх соёл, өв уламжлалын давуу тал, нөөцийг ашиглан нутгийн иргэдэд тулгуурласан нүүдлийн аялал жуулчлалыг тогтвортой хөгжлийн зарчимд нийцүүлэн хөгжүүлэх зорилготой.

### 2.2 НҮҮДЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛУУД БА СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ:

Эрхэм зорилгоо хэрэгжүүлэхийн тулд дараах стратегийн зорилтуудыг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх аялал жуулчлалын эрх зүйн орчин, дэд бүтэц, менежментийг боловсронгуй болгох
2. Монгол улсын Нүүдлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэх
3. Нүүдлийн аялал жуулчлал хөгжүүлэхэд орон нутгийн хөгжил, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах
4. Олон улсын ба бүс нутгийн хамтын ажиллагаанд суурилсан Монгол улсын нүүдлийн аялал жуулчлалын хөгжилд шинэ технологи, инновацийг нэвтрүүлж, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэх

Эдгээр стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд төлөвлөгөөний хэрэгжих хугацааг дунд хугацааны 2 үе шатанд хуваан үзэж үйл ажиллагааны зорилтуудыг тодорхойлсон болно.. Үүнд:

НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ: 2020 – 2025 ОН

ХОЁРДУГААР ҮЕ ШАТ: 2026 – 2030 ОН

**Стратегийн зорилтууд ба тэргүүлэх чиглэлүүд:**

| **Стратегийн зорилтууд** | **Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030-тай нийцэх байдал** |
|---|---|
| Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх аялал жуулчлалын эрх зүйн орчин, менежментийг боловсронгуй болгох | **2016-2020 онд:**<br>1. Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах;<br>2. Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх;<br>**2021-2025 онд:**<br>1. Дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах; |
| Монгол улсын Нүүдлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэх | **2016-2020 онд:**<br>1. Олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын онцлог дүр төрхийг бүрдүүлэх;<br>**2021-2025 онд:** |

| | |
|---|---|
| | 2. Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх;<br>3. Аялал жуулчлалын олон төрөл, улирлын чанартай аялал жуулчлалыг хөгжүүлэх;<br>**2026-2030 онд:**<br>1. Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх; |
| Нүүдлийн аялал жуулчлал хөгжүүлэхэд орон нутгийн хөгжил, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах | **2021-2025 онд:**<br>1. Бүсийн хэмжээнд олон улсын аялал жуулчлалын замналд нэгдэх;<br>**2026-2030 онд:**<br>1. Аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэх; |
| Олон улсын ба бүс нутгийн хамтын ажиллагаанд суурилсан Монгол улсын нүүдлийн аялал жуулчлалын хөгжилд шинэ технологи, инновацийг нэвтрүүлж, маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэх | **2021-2025 онд:**<br>1. Монголын нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын сурталчилгааг тасралтгүй сайжруулах;<br>2. Нүүдлийн соёл, аялал жуулчлалын Монгол брэндийг дэлхийд сурталчлах; |
| Нүүдлийн аялал жуулчлалыг сургалт, судалгаанд суурилан хөгжүүлэх | **2016-2020 онд:**<br>1. Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах;<br>2. Байгаль орчин, эрүүл ахуйн шаардлага хангасан эко аялал жуулчлалын бүсүүд, бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх;<br>**2021-2025 онд:**<br>Дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах; |

***Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх стратеги:***



## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Үйл ажиллагааны жагсаалт | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжүүлэх хугацаа | Үр дүн / Таамаглал | Хэрэгжилтийг хариуцах, хамтран хэрэгжүүлэх байгууллага | Шаардлагатай төсөв */Сая төгрөг/* |
|---|---|---|---|---|---|---|
| *Зорилт 1. Нүүдлийн аялал жуулчлал хөгжүүлэх эрх зүйн орчин, дэд бүтэц, менежментийг боловсронгуй болгох*<br>Дараах бодлогын баримт бичгүүдийн тодорхой зүйл, заалтуудад үндэслэн энэхүү зорилтыг тодорхойлон үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан болно. Үүнд: “**Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 2.1.2-ийн I,II үе шат,** “Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.1, “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн 2.1.3, “Хөгжлийн зам үндэсний хөтөлбөр”-ийн зорилт 8 зэрэг болно. | | | | | | |
| 1 | Төрөөс аялал жуулчлал хөгжүүлэхээр чиглэлээр гаргах бодлогын баримт бичгүүд, эрх зүйн баримт бичгүүдэд НАЖ-ын төлөвлөгөөнөөс тусгах<br>Үүнд:<br>-Аялал жуулчллалын тухай хууль<br>-Орон нутгийн хөгжлийн дэд хөтөлбөрүүд<br>-ТХГН-ийн аялал жуулчлалын төлөвлөгөө<br>-Бусад эрх зүйн баримт бичгүүд | Холбогдох эрх зүйн баримт бичгүүдийг мөрдөж хэвшүүлэх, зорих газар, үзмэр, бүтээгдэхүүн, эвентийг төсөл төлөвлөгөөний дагуу хөгжүүлж, орон нутгийн ЗД-ын мөрийн хөтөлбөрүүд, аялал жуулчлалын дэд хөтөлбөр, мастер төлөвлөгөө, ТХГН-уудын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулна. | 2020-2030 | Эрх зүйн орчин бүрдсэнээр нүүдлийн аялал жуулчлал хөгжих тааламжтай орчин бий болох, бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоо сайжирна. | БОАЖЯ, АЖХТ, аймгуудын ЗДТГ, БОАЖГ, Мэргэжлийн хяналтын алба | |
| 2 | Монгол улсад нүүдлийн аялал жуулчлал хөгжүүлэх дэд хөтөлбөрийн санал боловсруулах | Дэд хөтөлбөр боловсруулах, батлуулах | 2020 | Дэд хөтөлбөр боловсруулснаар НАЖ хөгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гаргаж, хэрэгжилтийг сайжруулж, үр дүнрүү чиглүүлэх | БОАЖЯ, АЖХТ, Төрийн болон ТББ, судлаачид | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Торгоны зам дагуух НАЖ-ын тусгайлсан хөтөлбөр боловсруулж, энэ чиглэлээр аялах жуулчдад зориулсан аяллын нэгдсэн визтэй болгоно. Үүнд:<br>- БНХАУ, Узбекстан, Казакстан болон бусад орнууд | Голлох зах зээлийн орнууд, Торгоны замын дагуух орнуудын жуулчдын тоо өсөх | 2020-2022 | Нүүдлийн аялал жуулчлал хөгжсөн бүсүүдэд хөнгөлөлттэй визээр зорчих боломжийг бүрдүүлсэн байна. | БОАЖЯ, АЖХТ | |
| 4 | Нүүдлийн аялал жуулчлал ба хотуудын хөгжил олон улсын чуулга уулзалтыг 2 жилд нэг удаа зохион байгуулах талаар судлах, хийж гүйцэтгэх | НАЖ-ын олон улсын төв болох зорилгын хүрээнд дэлхийн нүүдэлчин улс орнуудын дунд чуулга уулзалт зохион байгуулах, ДАЖБ-аар дэмжүүлэх, эрх зүйн баримт бичгүүдэд тусгуулах | 2022, 2024, 2026, 2028, 2030 | ДАЖБ-аар дэмжүүлэх, эрх зүйн баримт бичгүүдэд тусгуулан зохион байгуулж тогтмолжуулна. | Дэлхийн аялал жуулчлалын байгууллага, БОАЖЯ | |
| 5 | | НАЖ-ын стандарт хэлэлцэн батлуулах | 2022 | НАЖ-ын стандарттай болж, үйл ажиллагаанд мөрдөж эхэлнэ. | БОАЖЯ, АЖХТ, СХҮТ | |
| 6 | НАЖ-ын Стандартын шалгуурыг хэрэгжүүлэх практик заавар, удирдамж боловсруулах, холбогдох чиглэлээр олон улсын, бүсийн ижил төсөөтэй байгууллагуудтай хамтран ажиллах | Стандарт хэрэгжүүлэх заавар, удирдамж боловсруулах, гадаад дотоодын байгууллагатай хамтран ажиллах | 2023 | НАЖ-ыг стандартын дагуу, олон улсын болон үндэсний байгууллагуудтай хамтран ажиллаж үйл ажиллагаа жигдэрсэн байна. | БОАЖЯ, АЖХТ, СХҮТ | |

*Зорилт 2. Монгол улсын нүүдлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлж, үйлчилгээний чанарыг олон улсын түвшинд хүргэх*

Дараах бодлогын баримт бичгүүдийн тодорхой зүйл, заалтуудад үндэслэн энэхүү зорилтыг тодорхойлон үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан болно. Үүнд: “**Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 2.1.2-ийн I,II,III үе шат, “**Монгол Улсын Ногоон хөгжлийн бодлого”-ын стратегийн зорилт 1, 3.1.7, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн 4.2.1, 4.2.3 зэрэг болно.

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 7 | Торгоны замын дагуух улс орнуудтай хамтран НАЖ-ын бүтээгдэхүүнүүдийг бий болгох<br>- Эвентүүд<br>- Маршрутууд<br>- Маршрутын дагуух бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг нэмэгдүүлэх | Хамтын ажиллагааны гэрээ байгуулах, Торгоны замын бусад улс орнуудтай хамтарсан аяллууд зохион байгуулах | 2020-2030 | Торгоны замын дагуух улс орнуудтай хамтран ажиллах гэрээ хэлцэл байгуулна. Хамтран ажиллана. | Торгоны замын ОУ-ын байгууллагууд, БОАЖЯ | |
| 8 | “Торгоны замын үдэш” олон улсын жуулчдад зориулсан арга хэмжээг тогтмол зохион байгуулах | Олон төрлийн арга хэмжээг багтаасан, чанар, хамрах хүрээ, онцлог байдлыг тодотгох | 2020-2030 | Торгоны замаар ирэх жуулчдын урсгалыг нэмэгдүүлнэ. Бөө, одон орон судлал, тэмээчид, нутгийн иргэдтэй хамтран олон төрлийн арга хэмжээтэй жил бүр говьд тогтмол зохион байгуулагддаг шөнийн эвентээр гадаадын жуулчдыг татдаг болсон байна. | БОАЖЯ<br>Өмнөговь аймгийн ЗДТГ<br>Монголын бөөгийн нэгдсэн эвлэл, холбоо<br>Одон орон судлалын хүрээлэн | |
| 9 | Монгол үндэсний хоол, ундны үйлчилгээ үзүүлэх талаар жуулчны баазуудад зөвөлгөө өгөх, монгол хоолны сургалт зохион байгуулах, аймгуудын брэнд хоолны эвентүүдийг бий болгох | Аймгуудын хоолны үзэсгэлэнг жуулчдад зориулан гаргах, жуулчдаар хоол хийлгэх, сошал орчноор дамжуулан, жуулчдаар сурталчилгаа хийлгэх | 2020-2030 | Аймаг бүрийн брэнд хоолны жагсаалт гарна. Жуулчдад хоолоо танилцуулж, үйлчилнэ. Жуулчдыг татах бүтээгдэхүүн үйлчилгээ чанаржина. | БОАЖЯ, Аймгуудын ЗДТГ, АЖХТ, ТББ, тур операторууд | |
| 10 | Монгол хувцасны загварын шоу арга хэмжээг жилдээ 1-2 удаа зохион байгуулах | Дэлхийн улс орнуудад загварын шоу арга хэмжээ зохион байгуулах | 2020-2030 | Олон улсад алдартай загварын шоу арга хэмжээ болсон байна. | Дэлхийд алдартай загварын байгууллага, БОАЖЯ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 11 | Аялал жуулчлалын мэргэжилтнүүд, бизнес эрхлэгч нарт зориулсан “Нүүдэлчдийн соёлын тайлбар толь бичиг” бүтээх | АЖБХН, судлаач нартай хамтрах | 2021 | Аялал жуулчлалын мэргэжилтнүүд, бизнес эрхлэгч нарт зориулсан НАЖ-тай холбоотой концевци, тайлбар толь бичигтэй болсон байна. | БОАЖЯ, БСШУСЯ, АЖБХН, судлаачид | |
| 12 | НАЖ-г бүсчилэн хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах | Нүүдэлчин малчин иргэд, угсаа гарал, аж ахуй, эдийн засаг, дэд бүтцийн хөгжлийг харгалзан 5 бүс нутаг, 12 дэд бүсээр хөгжүүлнэ. | 2020-2030 | НАЖ-г бүсчилэн хөгжүүлснээр аймаг бүрийн аялал жуулчлалын ялгагдах онцлог бий болж, аялал жуулчлалын бүтээгдэхүүний тоо өснө. | БОАЖЯ, аймгуудын БОАЖГ, НИТАЖ-ын бизнес эрхлэгч нар | |
| 13 | Аймаг бүр нүүдэлчдийн болон соёлын брэнд бүтээгдэхүүнүүдээ дэлхий дахинд сурталчилах арга замуудыг гаргана. Үүнд:<br>- Нүүдэлчдийн зан заншил, аж ахуйг харуулсан баримтат кино уралдаан<br>- Гэрэл зурагчдын бүтээлүүдээр дамжуулан олон улсад суратчилах, уралдаан зарлах<br>- Брэнд бүтээгдэхүүнийг тодорхойлж түүгээр дамжуулан жуулчдыг татах | Биет болон биет бус өв, язгуур урлаг, гар урлал, НАЖ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээг зарлах, уралдааныг 4 жилд нэг удаа зарлах, брэнд бүтээгдэхүүнийг өдөр тутам сурталчилах | 2020-2030 | Аймаг тус бүр нүүдэлчдийн соёлын брэнд бий болгосон байна. Баримтат кино, гэрэл зургуудаар дамжуулан жуулчдад тогтмол мэдээлэл дамжуулна. | БОАЖЯ, Аймгуудын ЗДТГ, БОАЖГ | |
| 14 | “Дэлхийн нүүдэлчдийн наадам”-д улс орны баг тамирчдыг зохион байгуулалттай тогтмол оролцуулах | Дэлхийн нүүдэлчдийн наадам зохион байгуулах чиглэл, үйл ажиллагааг боловсруулах, тамирчдын тоог | 2021-2030 | Тогтмол оролцож, Монгол Улсыг сурталчилсан байна. Оролцогч тамирчдын амжилт гаргах, дэлхийн 140 гаруй оронд 200 | БОАЖЯ , БСШУСЯ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тогтмол нэмэгдүүлэх, оролцох спорт уралдааны тоог нэмэгдүүлэх, урлагийн томоохонүзүүлбэрийн багтай оролцох | | гаруй мэдээллийн хэрэгслээр болон 80000 жуулчнаар дамжуулан сурталчилгаа хийнэ. | | |
| 15 | “Монгол өртөө” цайны замын аялал жуулчлалын эвент, маршрут бүхий хөтөлбөрүүдтэй болох | НАЖ-ын шинэ бүтээгдэхүүн бий болох, Цайны замын бүтээгдэхүүн үйлчилгээ олшрох | 2021-2030 | Цайны замын өртөөчилсөн маршрутуудыг тогтоож эвент зарлаж, жуулчдад мэдээлэл, сурталчигаа хүргэх | БОАЖЯ Дархан-Уул аймгийн ЗДТГ | |
| 16 | Соёлын биет бус өвийн “Нүүдэлчин Монгол” наадмыг олон улсын хэмжээнд зохион байгуулах | “Нүүдэлчин Монгол” наадам зохион байгуулах | 2023-2025 | Арга хэмжээг 2 жил тутам зохион байгуулж, тогтмолжуулсан байна. | БСШУСЯ СУГ, Төрийн болон ТББ, мэргэжлийн урлагийн байгууллага | |
| 17 | Нүүдлийн соёлын аялал жуулчлалтай холбоотой эвентүүдийн цар хүрээг өргөжүүлж, үнэлэх, эрэмбэ тогтоох | Одоо зохион байгуулагдаж буй эвентүүд, цаашид бий болох эвентүүдийн уялдааг хангах, аялал жуулчлалын улирлын хамаарлыг багасгах ашиглах, mega буюу дэлхийн, үндэсний, орон нутгийн зэргээр үнэлэх, эрэмбэлэх | 2021-2023 | Эвентүүдэд оролцогч жуулчин, тур операторууд, ТББ-уудаар дамжуулан сурталчилгаа хийлгэсний үр дүнд эвентүүдэд оролцогч гадаад иргэдийн тоо жилд 3-15% өссөн байна. | БОАЖЯ, НАЖГ, ТББ-ууд, аймгуудын БОАЖГ, тур операторууд | |
| 18 | Дэлхийн нүүдэлчдийн Этно олимпыг зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах | Этно олимп зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдаж, | 2023-2026 | Этно олимп зохион байгуулах боломжтой улсын жагсаалтад Монгол Улс багтсан | БОАЖЯ, БСШУСЯ, Төрийн болон ТББ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | холбогдох судалгаа, төлөвлөгөө гаргах | | байна. ОХУ-ын этно спортын холбоотой хамтрач ажиллана. 4 жилд нэг удаа Монгол улсад зохион байгуулах тал дээр хамтран ажиллана. Этно спортын бүхий л төрлүүдэд тамирчдыг оролцуулах, дэлхий нийтэд Монгол улсыг гадаад орны баг тамирчид, сошиол орчинд сурталчилгаа хийгдэж НАЖ-ыг сурталчилна. | | |
| 19 | Нүүдэлчдийн амьдралтай танилцах нөөцийг тодорхойлох, нутгийн иргэдтэй хамтран үнэ цэнэ, үнэлэмжийг бусдад түгээх | Нөөцийн болон үнэлэмжийн судалгаа хийх, нийтийн хүртээл болгох арга замыг тодорхойлох | 2021-2023 | Нүүдэлчдийн амьдралтай танилцах нөөцийг тодорхойлсноор гадаад, дотоодын жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх | БОАЖЯ, АЖХТ, судлаачид | |
| 20 | Монгол улсын Торгоны зам, Их Цайны замын аяллын маршрутыг албан ёсоор баталгаажуулах | Монгол Улсын Торгоны зам, Их цайны замын аяллын маршрут баталгаажуулах | 2020-2021 | Албан ёсны баталгаажсан аяллын маршруттай болох | БОАЖЯ | |
| 21 | Торгоны ба цайны замын Монгол дахь аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах | Мастер төлөвлөгөө боловсруулах | 2021-2022 | Мастер төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангаж ажиллана. | БОАЖЯ | |
| 22 | Монголын “Цайны зам”-ы нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх цогц хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | Цогц хөтөлбөр, хэрэгжүүлэх үйл ажиллагааны | 2022-2025 | “Цайны зам”-ын нүүдлийн аялал жуулчлалын хөтөлбөр хэрэгжиж, Монголын | БОАЖЯ, АЖХТ, судлаачид, тур операторууд | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | төлөвлөгөө боловсруулах | | НАЖ-ын нэг гол брэнд хөтөлбөр болсон байна. | | |
| 23 | “Цайны зам”-ын нүүдлийн аялал жуулчлалыг хөрш орнуудын ба олон улсын аялал жуулчлалын маршруттай холбох хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | “Цайны зам”-ын аялал жуулчлалыг олон улсын аялал жуулчлалын маршруттай холбосон хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлж, нийтийн хүртээл болгох, дэлхийн зах зээлд сурталчлах | 2023-2025 | “Цайны зам”-ын аялал жуулчлалын хөтөлбөр боловсруулж, олон улсын аялал жуулчлалын хөтөлбөрт холбосноор дэлхийд таниулна. (НҮБ-ийн ДАЖБ-ын төсөл хөтөлбөрүүд, Олон улсын Торгоны замын аялал жуулчлал, ОХУ-ын Аугаа Их Цайны зам ба хил орчмын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, БНХАУ-ын Түмэн Газрын Цайны зам г.м.) | БОАЖЯ, АЖХТ | |
| 24 | Хархорин хотыг НАЖ-ын жишиг хот болгон төлөвлөн хөгжүүлэх, Хархориноор дайрсан Торгоны замын аялал жуулчлалын замналыг бий болгох | Хархорин хотыг жишиг хот болгон хөгжүүлэх төлөвлөөгөө боловсруулах, шинэ зам замналыг бий болгон хэрэгжүүлэх | 2022-2030 | Хархорин хот НАЖ-ын жишиг хот болон хөгжиж, үйл ажиллагаа жигдэрсэн байна. | БОАЖЯ, Орон нутгийн төрийн байгууллагууд | |
| *Зорилт 3. Нүүдлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд орон нутгийн хөгжил, оролцогч талуудын хамтын ажиллагааг сайжруулах*<br>Монгол улсын болон орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлэхүйц, оролцогч талуудын эрх ашгийг уялдуулсан, гадаад, дотоодын аялагч жуулчдад зориулсан үзвэр, үйлчилгээний тоог нэмэгдүүлэх, чанаржуулах<br>Дараах бодлогын баримт бичгүүдийн тодорхой зүйл, заалтуудад үндэслэн энэхүү зорилтыг тодорхойлон үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан болно. Үүнд: “**Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 2.1.2-ийн II,III үе шат,** “Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн 4.3.6, “Эдийн засгийг сэргээх хөтөлбөр”-ийн 2.1 зэрэг болно. | | | | | | |
| 25 | Аялал жуулчлал эрхлэгч нутгийн иргэдээс жил бүр шилдэг | Шилдэг санаачилга, шилдэг ажлыг | 2020-2021 | Шилдэг санаачилгыг дэмжин, зарлан | БОАЖЯ, Худалдаа аж үйлдвэрийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | санаачилга, шилдэг ажлыг шалгаруулж, урамшуулах | шалгаруулах удирдамж батлах | | алдаршуулсан байна. Үгээр дамжуулан НАЖ-ын тогтмол зохион байгууллагддаг ажлуудын чанар сайжирна. | танхим, Аймгуудын ЗДТГ | |
| 26 | “Дэлхийн Монгол Наадам” цуврал эвентийг санаачлан зохион байгуулах | Цуврал эвентийн хөтөлбөр боловсруулах, бүс нутгийн хэмжээнд зохион байгуулалж, Монгол угсаатнууд оролцох боломжтой | 2020-2030 | Цуврал эвентийг жил бүр тогтмол зохион байгуулах, үндэсний урлаг, соёл, НАЖ-ын бүтээгдэхүүнүүд бүгдийг гаргаж болно. Дэлхий томоохон телевизүүдтэй хамтран ажиллана. | БОАЖЯ, БСШУСЯ, Аймгуудын ЗДТГ, Дэлхийн томоохон телевизийн багууд | |
| 27 | Гадаадад суугаа Монголчуудын дунд зохион байгуулагдаж буй үйл ажиллагаа, эвентийг тухайн улсад нь сурталчилах | Мэргэжлийн гэрэл зурагчин, зураглаач, олон улсын хэмжээнд блог хөтлөгч монголчуудыг ажиллуулах | 2020-2030 | Гадаад улс орон бүрт амьдардаг иргэдийн баяр, үйл ажиллагаагаар дамжуулан НАЖ-ыг сурталчилах, жуулчдын тоо өсөлт нэмэгдэнэ. | Гадаадад суугаа Монголчуудын холбоо Элчин сайдын яам | |
| 28 | Монгол улсад аялах, ажиллах, амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлж, дижитал нүүдэлчдийн голлох зорин очих газрын нэг болох | Дижитал нүүдэлчдэд зориулсан хөтөлбөр маршрут гаргаж, уулзалтуудыг зохион байгуулах www.nomadlist.com-д дээгүүр зэрэглэлтэй болоход зорих, дижитал нүүдэлчдийн тоог нэмэгдүүлэх, сурталчилах | 2020-2030 | Дижитал нүүдэлчдийг голлох зах зээлээ болгосон Индонез улстай өрсөлдөхүйц болсон байна. | МАЖХ<br>Тур операторууд<br>Дижитал нүүдэлчдийн нийгэмлэг | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| *Зорилт 4. Олон улсын ба бүс нутгийн хамтын ажиллагаанд суурилсан Монгол улсын нүүдлийн аялал жуулчлалын хөгжилд шинэ технологи, инновацийг нэвтрүүлж маркетингийн үйл ажиллагааг эрчимжүүлэх*<br>Монгол улсын нүүдлийн аялал жуулчлалыг дэлхийд сурталчилан таниулах, маркетингийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулах, шинэ технологи, инновацийг нутагшуулах<br>Дараах бодлогын баримт бичгүүдийн тодорхой зүйл, заалтуудад үндэслэн энэхүү зорилтыг тодорхойлон үйл ажиллагааны төлөвлөгөө гаргасан болно. Үүнд: “**Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 2.1.2-ийн II үе шат,** “Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийн 4.1.8, 4.6.4, “Орос-Монгол-Хятад улсын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөр”-ийн 28,29 зэрэг болно. | | | | | | |
| 29 | Монголын Улсын Үндэсний брэнд, гадаад сурталчилах агуулгад монгол гэр, ноолууран бүтээгдэхүүн, үндэсний дээлийг тусган сурталчилах | Монгол гэр, ноолууран бүтээгдэхүүн, үндэсний дээлийг үндэсний брэнд болгох, дээрх бүтээгдэхүүнээр хийсэн баримтат кино бүтээж, уралдаан зарлах, тогтмол үндэсний дээлээр гоёдог хүмүүсийг алдаршуулах | 2020-2030 | Үндэсний брэнд, гадаад сурталчилгааны агуулга уялдсан байна. Дэлхийн жуулчдын анхаарлыг татахуйц бүтээгдэхүүнээр дамжуулан брэнл бий болгосон байна.. | БОАЖЯ<br>МУ-ын Брэндийн зөвлөл | |
| 30 | Монгол гэрийг дэлхийд соёлын өвд бүртгүүлэх | ЮНЕСКО-гийн дэргэдэх соёлын өвийн бүртгэлийн газрын шалгуурын дагуу бичиг, баримтаа бүрдүүлэх, шаардлага хангах | 2020-2025 | Монгол гэрийг дэлхийн соёлн өвд бүртгүүлсэн байна. | БОАЖЯ | |
| 31 | НАЖ-аар дагнасан ETHNO MART олон улсын үзэсгэлэн зохион байгуулах | Нүүдлийн уламжлалтай гэх 100 гаруй улс орнуудын дунд жил бүр тогтмол НАЖ-ын үзэсгэлэн зохион байгуулах, жуулчдын | 2020-2030 | НАЖ-ын үзэсгэлэнд оролцох улс орнуудын тоог нэмэгдүүлэх, Монгол Улсыг зорилтот зах зээлд сурталчилсан байна. | БОАЖЯ,<br>НЗДТГ, МАЖХ, АЖҮТ, Төрийн болон ТББ, тур операторууд | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | татах томоохон арга хэмжээ болно. | | | | |
| 32 | Монгол орны нүүдэлчин соёлын онцлогийг түлхүү харуулсан соёлын өдөрлөгүүдийг голлох зах зээлийн орнуудад зохион байгуулах | Соёлын өдөрлөгүүдийн чиглэл, агуулга, хугацаа, давтамж, хамрах хүрээ, зохион байгуулагдах газар зэргийн нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах | 2023-2030 | Жилд 10-аас доошгүй улсад урлаг, соёл, аялал жуулчлалын өдөрлөг зохион байгуулсан байна. | БСШУСЯ, БОАЖЯ, ГХЯ, Төрийн болон ТББ | |
| 33 | Монголын нүүдлийн аялал жуулчлалын тухай баримтат кино хийж, олон улсад сурталчилах | Баримтат кино хийх төлөвлөгөө боловсруулж, уран бүтээл туурвих | 2023-2025 | Монгол Улсыг зорилтот зах зээлд сурталчилсан байна. Олон улсын 5-аас доошгүй хэлээр, 100-аас дээш телевизээр гаргасан байна. | БСШУСЯ, БОАЖЯ, Төрийн болон ТББ, мэргэжлийн урлагийн байгууллага, уран бүтээлчид | |
| 34 | Гадаадын алдартай зураглаач, видео контент бэлддэг аж ахуйн нэгж, аялагч нарыг Монгол Улсад урьж ажиллуулах | Урьж ажиллуулах байгууллага, хувь хүмүүстэй холбоо тогтоох, гэрээ байгуулах | 2025-2030 | Жил бүр 50-аас дээш контентийг зорилтот зах зээлд сурталчилсан байна. | МУ-ын брэндийн зөвлөл БОАЖЯ, Төрийн болон ТББ | |
| 35 | Монгол Улсын бүх байршуулах үйлчилгээний газруудыг Олон улсын Глобал түгээлтийн систем, интернет түгээлтийн системд бүртгэх | Байршуулах үйлчилгээний байгууллагуудын интернет системд бүртгэх бүртгэлийн нэгдсэн мэдээлэл үүсгэх | 2023-2026 | Бүх байгууллагуудыг бүртгэж дуусгасан байна. | МУ-ын брэндийн зөвлөл БОАЖЯ | |
| 36 | Street gallery exhibition гаргах, ямар нэгэн аймаг орон нутаг, жуулчдын төв замналын дагуу | Төв замналын дагуу, аймгуудаас сонгон шалгаруулалт хийх замаар гудамжийг | 2020-2030 | НАЖ-ын бүтээгдэхүүн, үйлчилгээ бүхий сонгогдсон аймгуудад street gallery бүхий | БОАЖЯ, аймгуудын БОАЖГ, street gallery exhibition байгуулах сонирхол | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | гудамжны урлан байгуулах ажлыг эхлүүлэх | сонгох, барилга байгууламж, нүдэлчин аж ахуйн өлгий бүтээгдэхүүн үйлчилгээг байршуулах, жуулчдыг татах, бусад оролцогч талуудтай хамтран ажиллах | | гудамж байгуулсан байна. | бүхий иргэд, ААНБ-ууд | |
| 37 | Монгол орны нүүдлийн соёлын аялал жуулчлалыг сурталчилсан Холливудын кино хийж, олон улсын кино наадмуудад оролцох | Кино хийх уран бүтээлчдийн багийг бүрдүүлэх, судалгаа хийх, кино зохиол бичих, бүтээх, нийтийн хүртээл болгох | 2027-2030 | Монгол Улсыг зорилтот зах зээлд сурталчилсан байна | БСШУСЯ, БОАЖЯ, Төрийн болон ТББ, мэргэжлийн урлагийн байгууллага, уран бүтээлчид | |
| 38 | Язгуур урлагийн хамтлагуудыг олон улсын түвшинд сурталчилах таниулах | Язгуур урлагийн хамтлагуудыг олон улсын түвшинд гаргах, тэднээр дамжуулан жуулчдын татах | 2020-2030 | Язгуур урлагийн хамтлагуудаар дамжуулан жуулчдын татах, жилд 10-аас доошгүй хамтлагийг 10-аас доошгүй гадаад орнуудад тоглолт зохион байгуулсан байна. | БОАЖЯ, БССШУЯ | |
| 39 | “Торгоны зам” брэнд хөгжүүлэлт | Нөхцөл байдлын судалгаа хийх, түүх, соёлын өвийн хамрагдах хүрээг тодорхойлох, сэдэвчилсэн замналыг хөгжүүлэх | 2021-2025 | Нөхцөл байдлын судалгаанд тулгуурлан хамрах хүрээг тодорхойлон брэнд бий болсон байна. | БОАЖЯ<br>МУ-ын Брэндийн зөвлөл | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 40 | Монголын нүүдэлчин аж ахуйг төлөөлөх дүр гаргаж ирэх, брэндинг хийх | “Жангар-Монгол тууль”, “Бумбардай” зэрэг дүрүүдийн аль нэгээр нүүдэлчин аж ахуйг харуулсан видео контент хийж олон улсад цацах, Сонгогдсон баатрын дүртэй үндэсний хэмжээний ус ундаа, хувцас, бэлэг дурсгал, жижиг дунд үйлдвэрлэл, маскотуудыг бий болгох, худалдаанд гаргах | 2021-2030 | Дүрээр дамжуулан олон улсад “нүүдэлчин ахуй”-г сурталчилсан байна. Дүрийн бизнээсээр дамжуулан нутгийн иргэдийн жижиг дунд үйлдвэрлэлүүд эргэлтэд орсон байна. | БСШУСЯ, Хувийн хэвшлийн контент хөгжүүлэгч компаниуд | |
| 41 | “What 3word” хаягжилтын системд соёлын биет өвүүдийг бүртгүүлж, хаягжилтын каталог бий болгох | Соёлын биет өвүүдийг 3 үгтэй хаягжилтаар бүртгэж, байшлыг тодорхой болгох | 2021-2030 | Улсын хэмжээнд байгаа соёлын биет өвүүд бүгд бүртгэлд хамрагдсан байна. | БСШУСЯ, Соёлын өвийн хүрээлэн | |
| 42 | Нүүдэлчин зан заншилтай танилцах боломжтой энтертайнмент төвүүдийг хувийн хэвшилтэй хамтран байгуулах | Нүүдэлчин аж ахуйг харуулсан AR, VR zone болон бусад виртуал төхөөрөмжтэй энтертайнмент төвүүдийг ажиллуулах, Өмнөговь аймагт Динозавруудын амьдарч байсан орчинг AR технологиор үзүүлэх | 2021-2030 | Хувийн хэвшилтэй хамтран энтертайнмент төвүүдийг ажиллуулж эхэлсэн байна. | БСШУСЯ, Хувийн хэвшлийн байгууллагууд | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 43 | “Монгол нүүдэлчид” арга хэмжээг дэлхийд интернэт орчныг ашиглан контент хэлбэрээр сурталчилан таниулах | Монголчуудын уламжлалт хувцас, уламжлалт эдлэл хэрэглэлээ ашиглах талаар баримтат кино, хүүхэлдэй болон жүжигчилсэн хэлбэрээр сурталчилах | 2020-2030 | Олон улсад таниулах арга хэмжээг авч дэлхийд танигдах болно. | БОАЖЯ, ОУ-ын бусад байгууллагууд, мэргэжлийн урлагийн байгууллага | |
| 44 | “Нүүдлийн аялал жуулчлал-Монголын торгоны зам” вэб хуудсыг бий болгох | Вэб хуудас бий болгох, байршуулах, сурталчилах | 2021-2022 | Нүүдлийн аялал жуулчлал, Торгоны замын аялал жуулчлалын үндсэн гол бүсийн нэг болж, дэлхий дахинаа сурталчилах | БОАЖЯ, вэб дизайны компаниуд, судлаачид | |
| *Зорилт 5. НАЖ-ыг сургалт, судалгаанд суурилан хөгжүүлэх* | | | | | | |
| 45 | НАЖ-ын олон улсын сургалт, судалгааны төвийг байгуулж, ач холбогдол, үйл ажиллагааг нь олон улсад таниулах | MIVE аялал жуулчлал, сургалНөөц боломжоо ашиглан, сэргээн засварлаж тохижуулах, шаардлагатай материалаар хангах | 2020-2030 | Нүүдлийн аялал жуулчлалын олон улсын сургалт, судалгаа, хурал зөвөлгөөнийг санаачилж, зохион байгуулна. | БОАЖЯ | |
| 46 | Монгол үндэсний хоол, ундны үйлчилгээ үзүүлэх талаар жуулчны баазуудад зөвөлгөө өгөх, монгол хоолны сургалт зохион байгуулах | Аймгуудын хоолны үзэсгэлэнг жуулчдад зориулан гаргах, жуулчдаар хоол хийлгэх | 2020-2025 | Аймаг бүрийн брэнд хоолны жагсаалт гарна. Жуулчдад хоолоо танилцуулж, үйлчилнэ. | Аймгуудын ЗДТГ, АЖХТ, ТББ, тур операторууд | |
| 47 | Монголын нүүдэлчдийн соёлын онцлогийг тайлбарлах шат дараалсан сургалтуудыг зохион байгуулах | Богино хугацааны сургалт | 2020-2022 | Сургалтыг салбарын хэмжээнд жил бүр зохион байгуулсан байна. | БСШУСЯ, АЖБХН Эрдэмтдийн баг | |
| 48 | Монгол Улсад хөтөч тайлбарлагч бэлдэх сургалтын хөтөлбөрийг | Сургалтын хөтөлбөр болон нүүдэлчдийн | 2020-2021 | Хөтөч тайлбарлагч бэлдэх хөтөлбөрийг | БОАЖЯ НАЖГ, АЖБХН | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | баталж, нүүдэлчдийн соёлын агуулгыг дэлгэрэнгүй тусгах | соёлын цөм агуулгыг боловсруулж хэрэгжүүлэх | | баталж, хэрэгжүүлж эхэлсэн байна. | | |
| 49 | Нүүдэлчдийн соёлыг тайлбарладаг тусгай хөтөч нарт зэрэг олгосон байна. | Сургалт зохион байгуулах, хөтөч тайлбарлагч нараас шалгалт авч, зэрэглэл тогтоох | 2020-2021 | 50-иас доошгүй НАУ-ын мэргэшсэн хөтөч-тайлбарлагчийг бэлтгэсэн байна. | БОАЖЯ МУ-ын Аялал жуулчлалын зөвлөл, МХТХ | |
| 50 | НАЖ-ын оролцогч талуудын үйлчилгээний соёлыг дээшлүүлэх талаар шат дараалсан сургалтуудыг зохион байгуулах | Богино хугацааны сургалт | 2020-2022 | Бүх шатны үйлчилгээний байгууллагуудыг жилд 1 удаа сургалтад хамруулсан байна. | БОАЖЯ, аймаг, нийслэлийн ЗДТГ, мэргэжлийн холбоод | |
| 51 | Аялал жуулчлалд оролцож буй нүүдлийн уламжлал хадгалагч иргэдийн үйл ажиллагаанд зөвлөгөө өгөх, дэмжих, сургалт зохион байгуулах | Жилд 1-2 удаа сургалт, зөвөлгөө өгөх, хөнгөлөлттэй зээлд хамруулах | 2020-2030 | Аялал жуулчлалд оролцож буй нүүдлийн уламжлал хадгалагч иргэдийн уламжлал хадгалагдаж, орлого өсөх болно. | НАЖ-ыг эрхлэгч иргэд, БОАЖЯ | |
| 52 | Аялал жуулчлалын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт нүүдлийн аялал жуулчлал, соёлын өвтэй холбоотой хөтөлбөрийг тусгах, олон улсын түвшинд хүргэх | Үр дүнд суурилсан боловсролын хөтөлбөр (CDIO)-ийн дагуу сургалтын хөтөлбөрийг шинэчлэх, сургалт зохион байгуулах | 2022-2025 | Их, дээд сургуулиудын сургалтын чанар сайжирсан байна. | БСШУСЯ Мэргэжлийн их, дээд сургуулиуд, судлаачид | |
| 53 | АЖХТ-ийн дэргэд сонирхогч талуудын оролцоо бүхий НАЖ-н зөвлөлийг байгуулж ажиллуулах | НАЖ-ын зөвлөл байгуулах, үйл ажиллагаа төлөвлөх, хөгжүүлэх | 2022-2023 | НАЖ-ын зөвлөл нь Монгол орныг нүүдлийн аялал жуулчлалын олон улсын төв болох гол зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулна. | БОАЖЯ, АЖХТ | |
| 54 | НАЖ-ын стандартын сургагч, шалгагч, шинжээч нарыг бэлтгэх, | НАЖ-аар мэргэшсэн стандартын сургагч, | 2022-2024 | Стандартын сургагч, шалгагч, шинжээч нар | БОАЖЯ, АЖХТ | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | тэдэнд арга зүйн сургалт зохион байгуулж, үйл ажиллагааг зохицуулан удирдах | шалгагч, шинжээч нарыг бэлтгэх | | бэлтгэгдэж, НАЖ-ын үйл ажиллагааг зохицуулан удирдана. | | |

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. НҮҮДЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ТЭРГҮҮЛЭХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

### *4.1. Бодлогын бичиг баримтуудад тусгагдсан төсөл хөтөлбөрүүд*

